

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY



Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 10 сар. №19 (029)

www.mongolianeconomy.mn

Чинээлэг дундаж давхарга,
нам инфляци

“Танай улсад Азийн хамгийн
амжилттай яваа хоёр групп
хөрөнгө оруулж эхэллээ”



МӨНГӨНИЙ
ХАТУУ БОДЛОГО,
ДАРУУЛГАТАЙ ТӨСӨВ

Оюу Толгой ХХК
Улаанбаатар - 14240
Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө - 15
Моннис цамхаг
Утас: +976-11-331880
(дотуур утас 3800, 3801)
Факс: +976-11-331890
И-мэйл: OTLLCinfo@ot.mn

ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭГЧ
МОНГОЛЫН УУЛ
УУРХАЙН КОМПАНИ



ОЮУ ТОЛГОЙ – ТА БИДНИЙ БАХАРХАЛ

Рио Тинто болон Монгол улсын Засгийн газрын хамтран бүтээн байгуулж буй Оюу Толгой төсөл нь дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайн нэг болон хөгжиж байна.

Оюу Толгой төсөл нь Монгол улсын гэрэлт ирээдүйг цогцлоон бүтээх алсын хараатай ажиллаж, Монгол улсын эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд бодит хувь нэмрээ оруулан

бүтээн байгуулалтын үйл ажиллагаагаа өрнүүлж байна.

Монголын ирээдүйн шинэ хөгжлийг манлайлагч Оюу Толгой төслийг бүтээн байгуулахад мянга мянган Монгол залуус гар бие оролцож, олон зуун Монгол компани, ханган нийлүүлэгчид хувь нэмрээ оруулж, эх орныхоо ирээдүй, хойч үедээ үлдээх бахархал, түүхийн эхний хуудсыг бичилцэж байна.

Монгол улсын түүхэн дэх хамгийн том бүтээн байгуулалт Оюу Толгой төслийг барьж байгуулах эхний үе шатанд буюу 2013 он хүртэл нийт 7,8 их наяд төгрөгийн (6 тэрбум ам.доллар) хөрөнгө оруулалт хийх юм. Энэ хугацаанд Монгол улсын Засгийн газарт 900 гаруй тэрбум төгрөгийн (700 сая ам.доллар) татвар, төлбөр, хураамжийг төвлөрүүлж байна.

www.ot.mn
www.facebook.com/oyutolgoi





ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

300 САЯ АМ.ДОЛЛАРЫН БОНД

3 дахь удаагаа олон улсын санхүүгийн зах зээлд амжилттай арилжааллаа

Европийн дунд хугацааны үнэт цаасны 700 сая ам. долларын хөтөлбөрийн хүрээнд

МОНГОЛ УЛСААС АНХ УДАА

1 2007 онд 75 сая ам.долларын

2 2010 онд 150 сая ам.долларын бонд болон 25 сая ам.долларын хоёрдогч өглөг

3 2012 онд 300 сая ам.долларын
БОНД

хугацаа 3 жил
жилийн хүү 8.5%



Хамтарсан андеррайтер:



Төлбөр гүйцэтгэгч агент:



Хамтран зохион байгуулагч:



Утас: 1977 | Факс: 976-11-327028, 331155 | www.tdbm.mn

Зохион байгуулагч:



WORLD TRADE CENTER
ULAANBAATAR



MISHEEL GROUP
EXPO - FURNITURE - BUSINESS PARK

Санаачлагч:



WORLD TRADE CENTER
ULAANBAATAR

Дэмжигч:



DM DISTRIBUTOR MONGOLIA 2012

ҮЗЭСГЭЛЭН - СЕМИНАР - ХУДАЛДАА - 2012.11.9-11

БҮРТГЭЛ 10 сарын 15 ХҮРТЭЛ ЭХЭЛЛЭЭ

**МОНГОЛ ДАХЬ АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЮТЕР,
ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ,
ИМПОРТЛОГЧ, ДИЛЕР КОМПАНИУДЫГ УРЬЖ БАЙНА**

- Монголын зах зээлд нэрээ батлах
- Оригинал бараа бүтээгдэхүүнээ хуурамч бараанаас ялгах таниулах
 - Маркетинг, борлуулалт
- Шинэ барааг зах зээлд нэвтрүүлэх
- Бизнес уулзалтын боломжууд нэгдэнэ

*МОНГОЛ ДАХЬ ПЭРТҮЧЛЭХ ДИСТРИБЮТЕР КОМПАНИУД
ОРОЛЦОЖ, ДЭЛХИЙН БҮХ БРЭНД НЭТ ДОР ЦУТЛАРНА*

БҮРТГЭЛ:

2012.10.15 хүртэл "Мишээл Групп" ХХК байранд бүртгэнэ.

ҮЗЭСГЭЛЭН:

2012.11.9-11-нд МИШЭЭЛ ЭКСПО ТАНХИМ-д болно

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ:

WWW.DISTRIBUTORMONGOLIA.WEEBLY.COM
www.facebook.com/wtcub/events

МУХАУТ, МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛИЙН

ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА



ХӨНГӨЛӨЛТТЭЙ



88077064-88077063-95950811

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДЛУУД ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

**2012 оны аравдугаар сарын 12-ны 09.00 цагт
Чингис Хаан зочид буудал, хурлын танхим**

1. Др. Б.Алтанцэцэг (МУИС)
"Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн шинжилгээ"
2. Д.Ариунаа (ЭЗХЯ),
"Төв болон Хангайн бүс нутаг руу шилжих хөдөлгөөн"
3. Др. Б.Бат (МУИС),
"Хөрөнгийн хяналт: Монгол"
4. Др.Ц. Батсүх (СЭЗДС)
"Хүлээгдэж буй их хэмжээний хөрөнгийн урсгал болоод хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уул уурхай, аж үйлдвэрийн томоохон төслүүдээс үүдэлтэй Монгол улсын "Голланд өвчин"-д нэрвэгдэх эрсдлийн үнэлгээ"
5. Др.Ц. Болормаа (МУИС)
"Монгол дахь шилжих хөдөлгөөн"
6. Д.Гантулга (Гэрэгэ Партнерс ХХК),
"Хүн ам зүйн динамик ба нийгмийн даатгал"
7. Д.Ган-Очир (Монголбанк)
"Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: Инфляци, эдийн засгийн өсөлтийн хөтөч үзүүлэлтийг тодорхойлох нь"
8. Др. С. Даваасүрэн (МУИС)
"Эдийн засгийн өсөлт ба ядуурал"
9. Б.Мөнхзаяа (СЭЗДС)
"Монголын эдийн засгийн мөчлөгийн шинжилгээ ба индикатор"
10. Н.Мөнхнасан (Дэлхийн Банк)
"Дэд бүтцийн хөгжил ба засгийн газрын зардал"
11. Др. Б. Пүрэв (ХААИС)
"Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил"
12. Я.Ханзен (Азийн Хөгжлийн Банк),
"Уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн хөгжил болон баялгийн менежмент"
13. Др. Б.Эрдэнэбат (МУИС)
"Макро эдийн засгийн эрсдлүүд ба тэдгээрээс зайлсхийх арга замууд"

Зохион байгуулагч:



Хамтрагч байгууллага:



THE WORLD BANK

Мэдээллийн ивээн тэтгэгч:



National University of Mongolia

**e-mail: contact@eri.mn
Tel: +976-98196699
+976-353470**

Чинээлэг дундаж давхарга, нам инфляци



Монголбанкны өнөөгийн удирдлагын хувьд өмнө нь ярьдаг хэрнээ хийж чаддаггүй байсан зүйлийг мэргэжлийн банкирийн хувьд, залуу хүний хувьд зоригтой барьж авахаар шийдсэнд байгаа юм...11

Баян төсвийн балаг нь хаана бол

...Харамсалтай нь манай гишүүд төсвийн төслийг амин хувийн төсөв гэж андуураад зарлагаа хэтрүүлж, орлогоо дэндүү ихээр мөрөөдөх нь алдагдал хүлээх үндэс болдог... 16



“Танай улсад Азийн хамгийн амжилттай яваа хоёр групп хөрөнгө оруулж эхэллээ”



...Одоо бүгд л наашаа хараад хэрэв “Банпу”, “Липпо” хоёр хөрөнгө оруулж байгаа юм бол Монгол улс хөрөнгө оруулахад таатай газар байж таарна гэж бодож суугаа...20

Орон сууцны үнийн хандлага

Бидний үзэж байгаагаар Монголын барилгын сектор 2008-2010 оны хямралыг харьцангуй амжилттай даван туулсан гэж хэлж байна. 2008 он хүртэл орон сууцны үнэ тогтмол 15-20 хувийн өсөлттэй байсан. 36

Дүүрэг	Тансаг	Дундаж	Энгийн
ХУД	2,000	1,650	1,300
	3,200	2,200	1,500
ЧД	2,200	1,500	1,200
	2,600	1,900	1,600
БЗД	1,850	1,400	1,100
	2,200	1,700	1,450
БГД	1,400	1,300	1,250
	1,700	1,600	1,450
СХД	1,400	1,200	1,350
	1,800	1,200	1,000
СБД	2,300	1,350	1,100
	2,800	1,700	1,400

ЭДИЙН ЗАСАГ

- 10 Сонирхолтой эдийн засаг
- 11 Чинээлэг дундаж давхарга, нам инфляци
- 14 Баян төсвийн балаг нь хаана бол
- 18 “Цалинтай” хүүхдүүд
- 20 “Танай улсад Азийн хамгийн амжилттай яваа хоёр групп хөрөнгө оруулж эхэллээ”
- 24 Логистик инфляцийг хазаарлах шидтэй
- 27 Байгалийн баялгийн цаана
- 30 Орон сууцны үнийн хандлага

УУЛУУРХАЙ

- 32 Бидэнд ойрхон ирээдүй
- 34 Төв Европоос Монголд
- 38 Санхүүгийн зах зээл

ЭДИЙН ЗАСАГ

Монгол улсын 2011-2020 он хүртэлх бодит эдийн засгийн болон инфляцийн таамаглалыг гаргажээ. Уг төсөөллийг гаргахын тулд Оюутолгой, Тавантолгой зэрэг томоохон төслийн хэтийн зорилго, бодит үнэ болон ДНБ-ий өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, шинээр бий болох ажлын байр зэрэг хүчин зүйлийг харгалзан гаргасан байна.

Хөдөө аж ахуйн салбарын өсөлт энэ оны сүүлийн хагас жилд өндөр байх хүлээлт буй нь эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулахаар байна гэж Монголбанкнаас үзжээ. Нийт дүндээ эдийн засгийн өсөлт оны эцэст өмнөх оноос буурч 12-14 орчим хувьтай байх аж.

САНХҮҮ



Олон улсын “Фитч рейтинг” групп Монголын банкуудын эрсдэлийн үнэлгээний судалгаа хийсэн тухай “Ройтерс” агентлаг мэдээлжээ. Тус судалгаанд Монголын арилжааны банкууд гадаад валютын сангаа зузаатгах шаардлагатай болсон бөгөөд Төвбанк мөнгөний бодлогоо уян хатан байлгах хэрэгтэй

гэсэн байна. Түүнчлэн дотоодын валютын хөрвөх чадварыг сайжруулахын тулд яаралтай арга хэмжээ авахгүй бол оройтох магадлалтай гэжээ. Энэ онд 13 хувьтай байгаа манай ДНБ ирэх жил 10 хувь хүртэл буурах магадлалтай талаар мөн тус судалгаанд дурджээ.

УУЛ УУРХАЙ



ҮХШХ-ноос гаргасан “Уул уурхайн бусад салбарт үзүүлэх нөлөөлөл” судалгаагаар тус салбарын олборлолт нь бусад салбарт сөргөөр нөлөөлөөгүй гэсэн дүгнэлт гарсан байна. Уул уурхайн барилга, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл холбоо, цахилгаан, хий агааржуулалт зэрэг дэд бүтцийн салбарт эерэг нөлөөтэй байгаа нь судалгаагаар харагджээ. Харин хөдөө аж ахуйн салбарт уул уурхайн хамаарал сөрөг байдаг.

НИЙГЭМ

Монголын хүн ам 2010-2015 онд 276,1 мянгаар өсөх бөгөөд хөдөлмөрийн зах зээлд шинээр 299,9 мянган залуу шилжих аж. Харин зах зээлийн тойм

судалгаагаар 199,6 мянган ажлын байр шинээр бий болно гэх тооцоо гарчээ.

Ажиллах хүчний эрэлт салбараар		2010-2015
Уул уурхайн салбар		28,862.0
Дэд бүтцийн салбар		74,317.0
Үүнээс:	Барилга	54,695.0
	Төмөр зам	3,823.0
	Автозам	3,724.0
	Иргэний нисэх	2,175.0
	Тээвэр	5,800.0
Эрчим хүч		4,100
Боловсруулах аж үйлдвэрийн салбар		12,024.0
Хөдөө аж ахуйн салбар		43,400.0
Үүнээс:	Мал аж ахуй	32000.0
	Газар тариалан	11400.0
Нийтлэг үйлчилгээний салбар “хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм”-ийн дагуу тооцолсон дүн		24,982.0
Хот байгуулалтын салбар / оюутны хотхон, хөшигийн хөндий, шинэ орн сууцны хорооллууд/		13,000.0
Бүгд		196,585.0

Эх сурвалж: ҮХШХ

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Засгийн газрын ээлжит хуралдаанаар буудай үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас дотоодын гурилын үйлдвэр, Тариалан эрхлэлтийг дэмжих санд нийлүүлсэн стандартын шаардлага хангасан нэг тонн хүнсний улаан буудайн



урамшуулалд 100 мянган төгрөг өгөхөөр тогтов. Энэ оны улсын төсөвт улаан буудайн урамшуулалд зориулж, тонн тутамд 50 мянга, нийт 15 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд нэмэлтээр шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг ирэх оны төсөвт тусгаж, эхний улиралд багтаан олгохоор шийдвэрлэлээ.

БҮСИЙН ЭДИЙН ЗАСАГ

Инфляцийн түвшин энэ оны наймдугаар сард өмнөх сараас ялимгүй нэмэгдэж



жилийн 2.6 хувьд хүрсэн гэсэн урьдчилсан тооцооллыг Европын холбооны Статистикийн албанаас гаргаад байсан бөгөөд энэ сард дахин бататгалаа. Сүүлийн саруудад харьцангуй буурч Европын төвбанкны зорилтот түвшин болох жилийн хоёр хувь руу ороод байсан инфляцийн түвшин ийнхүү эргэн нэмэгдэх болсон нь газрын тосны үнийн өсөлт нөлөөлсөн гэж судлаачид үзэж байна.

Хятад, Энэтхэг улсын эдийн засгийн удаашрал Азийн бусад улсын эдийн засгийн өсөлтийг хойш татаж, Азийн хөгжлийн банк товлож



байсан бүсийн эдийн засгийн үзүүлэлтээ доош буулгахад хүргэлээ. Энэ нь 2008 оноос хойших хамгийн том бүсийн эдийн засгийн үзүүлэлтийг бууруулсан тохиолдол болж байгаа юм. Өнгөрсөн оны дөрөвдүгээр сард бүсийн эдийн засаг 6.9 хувиар өснө гэж төлөвлөж байсан ч Азийн хөгжлийн банк энэ удаад ДНБ-ий өсөлтийн төлөвөө бараг нэг хувиар буюу 6.1 хувь болтол нь бууруулаад байна.

ХЯТАД

Дэлхийн банкнаас

Хятадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, экспортын бүтээгдэхүүний эрэлт доошилсонтой холбогдуулан тус улсын эдийн засгийн өсөлтийн талаарх урьдчилсан тооцоолоо буурууллаа. Тус банк энэ оны тавдугаар сард Хятадын эдийн засаг 2012 онд 8.2 хувьтай өснө хэмээн хүлээж байгаагаа илэрхийлсэн бол энэ удаад дээрх таамаглалаа 7.7 хувь хүртэл бууруулж байгаагаа албан ёсоор мэдэгдлээ. Хятадын экспортын бүтээгдэхүүний голлох зах зээл Америк ба Евро бүсийн орнуудын эдийн засгийн асуудал тус улсын экспортод

хүнд цохилт өгч байгааг онцолжээ. Хэдийгээр тус улсын Засгийн газраас дотоодын эрэлтээ дэмжих замаар гадаад худалдааны эрэлт дэх бууралтаа нөхөхийг хичээж байгаа ч төдийлэн сайн хэрэгжиж өгөхгүй байгаа ажээ.

ОРОС

ОХУ барууны

компаниудад хойд туйл орчимд газрын тосны лиценз эзэмшүүлэх талаар хэлэлцэж эхэлжээ. Дэлхийн газрын тосны хоёрдогч том үйлдвэрлэгч ийнхүү томоохон буулт хийвэл гадаадын хөрөнгө оруулагчдын анхааралд зүй ёсоор орж эхэлнэ гэдгийг "Financial Times" мэдээлсэн. Өмнө нь зөвхөн төрийн өмчит



компанид олгодог байсан задгай тэнгисийн олборлолтын лицензийг гадаадын компаниудад олгож эхэлнэ гэдэг тус орны удаан оршин тогтносон уул уурхайн хаалттай хаант улсад төрийн эргэлт гарсантай адил том үйл явдал ажээ.

АНУ


АНУ-ын Засгийн

газраас энэ оны сүүлчээр төсвийн зардлаа бууруулж, татвар нэмэх бодлогыг хэрэгжүүлэх гэж байгаа нь үйлдвэрлэгчдэд дарамт болох төлөвтэй

байгааг эдийн засагчид сануулж байна. Мөн тус улсын ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр буюу найман хувьтай хэвээр. Гэхдээ АНУ-ын иргэдийн эдийн засгийн итгэлийн түвшин өнгөрөгч сард буураагүй харин ч нэмэгдсэн байгааг "The Thomson Reuters" компаниас гаргадаг судалгааны дүн харуулжээ. Хэрэглэгчдийн энэхүү эерэг үзэлд хувьцааны үнэ болон орон сууцны үнэлгээний өсөлт нөлөөлсөн байна.



Толгой яах вэ...!
Энгэртээ одонтой, дансандаа
мөнгөтэй хүнтэй суух л
чухал!



Шог зургийг А.Амарсайхан

ОНЦЛОХ

СОНИРХОЛТОЙ ЭДИЙН ЗАСАГ

И.ОТГОН

Монголын эдийн засаг ертөнцийн сонирхлын төвд ороод багагүй хугацаа өнгөрч буй. Байгалийн баялаг арвинтай Монгол улс хөгжих үү, эс хөгжих үү гэдгийн зааг дээр зогсоо. Харин хөгжлийн жолоогоо хаашаа залах нь одоогоор тодорхой бус ч хоног хугацаа өнгөрөх тусам Монголын эдийн засаг улам бүр сонирхолтой болж байна. Уг нь бол дотоод эдийн засгийн байдал тийм ч муугүй байгаа ч шинэхэн улстөрчдийн гэнэтийн “сюрприз”-үүдээс болж гадаад зах зээл дээр Монголын хувьцааны үнэ 23 дахин уначихаад байгаа нь тун таагүй зүйл гэдгийг Эдийн засаг хөгжлийн яамны дэд сайд О.Чулуунбат анхааруулж байсныг энд тэмдэглэе.

Монголын экспортын 90 хувийг дангаараа эзэлдэг уул уурхайн бүтээгдэхүүний тэр дундаа нүүрсний үнэ огцом унаж, экспорт зогсох хэмжээнд хүрсэн нь санаа зовоох асуудал болсон. Энэ талаар Монголд хөрөнгө оруулагчын жаргал, зовлонг сайн мэдэх “Гаррисон капитал” компанийн ерөнхий захирал Матью Вүүд “Үүнийг би түр зуурын бууралт гэж харж байгаа. Шинэ он гэхэд нүүрсний үнэ сэргэж эхлэхийг бид харна. Бүтээгдэхүүний үнэ өгсөж, уруудах нь мэдээж. Энд нэг зүйл тодорхой. Дэлхийн хүмүүс удаан хугацаанд нүүрс шатааж амьдрах нь илэрхий” гэж манай сэтгүүлийн энэ дугаарт өгсөн ярилцлагадаа онцлов. Харин Европын эдийн засгийн хямрал хэр удаан үргэлжлэх хандлагатай байгаа талаар туршлагатай эдийн засагч нараас сонирхоход, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал “Хувийн төсөөллөө хэлэх юм бол энэ хямрал тийм амар дуусчихгүй. 2008-2009 онд огцом унаад сэргэсэн шиг бол биш. Нэлээд удаан явцтай байх болов уу. Тэгэхээр Хятадын эдийн засагт нөлөөллөө үзүүлсээр байна гэсэн үг.

Үүний эсрэг Монгол юу хийж гарч ирэх вэ гэдэг л манай гол сорилт байх болно” хэмээсэн.

Тийм ээ, нүүрс, зэсийн үнэ таатай байх үед улсын төсөвт их мөнгө цутгаж, Засгийн газар олсоныхоо зоргоор бэлэн мөнгө тарааж, зарлага болгодог зан тогтсон. Харин ашигт малтмалын ханш уруудсан жил хаанаас мөнгө олох вэ гэж толгойгоо өвтгөдөг сонин улс. Угтаа бол төсөв өндөр орлоготой байсан ч зардал нь дагаад өсдөг биш, нөгөө талд орлого буурсан ч зайлшгүй хийхээр төлөвлөсөн зам, барилгын ажлаа зогсоодоггүй байх ёстой. Ийн орлого, зарлагын график нь зөрдөг төсөв, мөнгөний бодлого батлах нь Монголын “мөрөөдөл”. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүлийн аравдугаар сарын эхний дугаар УИХ-аар хэлэлцээд эхэлсэн ирэх оны төсөв, мөнгөний бодлогод чиглэлээ. Дэлхийн эдийн засагт доржилт өгөөд эхэлсэн хямралын сүүдрийг Монголын Засгийн газар хэр няхуур ажиж байгаа бол. Гуравхан жилийн өмнөх дэлхийн хямралаас амссан сургамжаасаа хэр суралцсан бэ гэдгийг харах цаг ирэв. Түүнчлэн уул уурхайн түүхий эдийн экспортод түшиглэсэн эдийн засгийн сууриа зугуухан өөрчлөх шаардлага бидний өмнө тулгарч байна гэдгийг төсөв, мөнгөний бодлогыг хэлэлцэн, баталдаг улстөрчид эрхи биш ойлгож байгаа биз ээ.

Мөн манай сэтгүүлч уул уурхайн салбарт монгол менежментийн авъяас чадлыг гайхуулж яваа “Хүннү коал” компанийн ерөнхий захирал Т. Лхагвадорж болон “Гаррисон Капитал” компанийн ерөнхий захирал Матью Вүүд нар Монголын ашигт малтмалын салбарын өнөөгийн байдал, цаашдын хандлагын талаар ярилцсаныг хүргэж байна. Бизнесийн эртний түнш тэд Монголын хэвлэлд анх удаа дэлгэрэнгүй ярилцлага өгч байгаа нь энэ. ■



МӨНГӨНИЙ БОДЛОГО

ЧИНЭЭЛЭГ ДУНДАЖ ДАВХАРГА, НАМ ИНФЛЯЦИ

И.ОТГОНЖАРГАЛ

Монголбанкны өнөөгийн удирдлагын хувьд өмнө нь ярьдаг хэрнээ хийж чаддаггүй байсан зүйлийг мэргэжлийн банкирийн хувьд, залуу хүний хувьд зоригтой барьж авахаар шийдсэнд байгаа юм.



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар /аравдугаар сарын 4-нөөс/ хэлэлцэж эхэллээ. Сүүлийн жилүүдэд инфляцийн өсөлтийг өдөөсөн Засгийн газрын бэлэн мөнгөний тараалттай холбоотойгоор мөнгөний бодлогын талаар ярьдаггүй ч хүнгүй болсон гэж хэлж болно.

Мөнгөний бодлогын зорилгыг эдийн засагчид ерөнхийд нь үнийн тогтвортой орчинд эдийн засгийн өсөлтийг дэмжих гэж энгийн тодорхойлдог ч ээдрээ төвөгтэй олон асуудал ээрдэг. Энэ нь энгийн уншигчид битгий хэл, эдийн засагчдын талцаж маргадаг мэргэжлийн сэдвүүдийн нэг болсон. Халамжийг хавтгайруулан олгож, эдийн засагт уул уурхайгаас их мөнгө цутгахын хэрээр улсын мөнгийг удирдах ухаанд улам ухаалаг бодлого шаардагдах аж. Монгол бол инфляцийг онилсон

мөнгөний хатуу бодлоготой орон. Эдийн засаг хурдацтай өсөж байгаа өнөөгийн нөхцөлд мөнгөний хатуу бодлого явуулах нь буруу, зөв гэж маргах нь бий. Тиймээс ирэх онд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн үүрэг хариуцлага, ач холбогдол өндөр байхын сацуу ихээхэн онцлогийг харуулах учиртай. Төрийн мөнгөний бодлогыг томъёолж, хэрэгжүүлдэг Монголбанкны ерөнхийлөгч ч Засгийн газар, Парламентын гишүүдийн адил шинэхэн учраас олон нийтийн хувьд үр дүнтэй, шинэлэг мөнгөний бодлогыг хүлээж суугаа. Албан тушаал нь л шинэ болохоос аз болоход Монголбанкны ерөнхийлөгчөөр Н.Золжаргал гэж туршлагатай эдийн засагч томилогдсон. АНУ-ын Харвардын их сургуулийг нийгмийн удирдлагаар төгссөн түүнийг угаасаа “Төвбанкны хүн” гэж хэлж болох. Баруунд боловсрол эзэмшиж ирсэнээсээ хойш

банк, санхүүгийн салбараас даахь холдоогүй тэрбээр 2010-2012 онд Монголбанкны дэд ерөнхийлөгчийн албыг хашиж байсан билээ. Одоо түүний юу хийхийг харах л үлдэв. Юу хийж байгааг нь харуулах хамгийн эхний алхам нь мөнгөний бодлогын үндсэн чиглэл юм. Түүнийг буруу, зөв гэж шүүмжлэгддэг мөнгөний хатуу бодлогыг зөөлрүүлэх болов уу, инфляцийг хазаарлан, “номхтогж” чадах болов уу, бизнесийн идвэхжил сайжрах болов уу хэмээн олон нийт хүлээлтийн харцаар ширтэж байна. Харин одоо хамтдаа Золжаргалын зорилго хийгээд Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөл рүү өнгийгөөд үзье. Түүний бодлого Монголбанкны өмнөх ерөнхийлөгч асан цагаан үстээрээ дуудуулан барин байж муу хэлүүлдэг байсан Л.Пүрэвдорж болон түүний багийнхны бодлогоос өөр байж чадах болов уу? »

► Монголбанк Засгийн газар нэг зүгт харлаа

Монголбанкны шинэ ерөнхийлөгч зоригтой, зорилготой ажиллаж байна гэсэн мессэжийг хэвлэлийнхэн хамгийн түрүүлнд олж харсан болов уу. Аравдугаар сарын 2-нд Монголбанкны удирдлагууд Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг УИХ-д хэлэлцүүлэхээр өргөн барьсантай холбоотой мэдээлэл хийв. Тус банкны тийм ч жижиг биш талбайтай хурлын заалыг сэтгүүлчид пиг дүүргэж, зарим нь гадна нь зогсож хүртэл мэдээлэл сонссон. Золжаргал ерөнхийлөгч ч мэдээллийн оршил хэсгээ телевизийн зураглаач нарт бичихийг зөвшөөрч, гол мэдээлэл өгөх хэсэг дээрээ тэднийг гаргасан. Мөнгөний бодлогоор сэтгүүлч нарт мэдээлэл гэхээсээ илүү мэдлэг өгөхүйц сайн илтгэл тавих шиг болсон. “За энэ ханшийн графикийг сайн хараад аваарай. Дахиж та бүхэн энэ сэдвээр олон бичиж ярих байх, буруу зөрүү асуулт тавьж, алдахгүй шүү” хэмээн байн байн анхааруулахаа мартаагүй. Үнэхээр л Төвбанкийг удирдахаас аргагүй мэргэжлийн хүн гэдгээ сэтгүүлчдэд цухас “гайхуулаад” авсан гэж болно. За үндсэн асуудал руугаа оръё.

Золжаргалын ярьж байгаагаас үзэхэд Монголбанкны инфляцийг онилсон мөнгөний хатуу бодлого үргэлжлэх нь байна. Олон хүнийг болгоомжлоход хүргээд буй ханшаар ч төдийлэн оролдохгүй нь бололтой. “Тэгээд юу хийх вэ гэсэн асуултад тэрбээр маш тодорхой, зорилготой зүйлүүдийг хийнэ, хийж ч байна, хийхээс ч аргагүй” гэв.


Монголбанк чинээлэг дундаж давхарга, нам инфляци гэдгийг 2013 оны мөнгөний бодлогын зорилт болгон тавьжээ. Бас л шинэ сонсогдохгүй байна. Өмнө нь Монголбанк мөн л нийгмийн дундаж ангийг чухалчилж, инфляцийг нам түвшинд барих гэж л мөнгөний бодлогыг хатууруулсан. Харамсалтай нь онилсон инфляци онож чадахгүй өнөөдрийг хүрсэн. Энэ нь мөнгөний бодлогыг шүүмжлэлд ихээхэн автахад хүргээд буй. Тэгвэл Золжаргал ерөнхийлөгч “мэс ажилбарт оруулаагүй” мөнгөний

бодлогоороо инфляцийг ирэх онд найман хувьд хүргэх боломжтой. Улмаар 2014-2015 онд инфляцийг 5-7 хувьтай байх нөхцөл бүрдүүлнэ гэдгээ хэвлэлийнхэнд ч Төрийн ордонд ч итгэлтэй хэлж ярьж байна. Яаж тэр вэ? Өмнөх Пүрэвдорж ерөнхийлөгч ч гэсэн ингээд амлаж болох л байсан шүү дээ. Учир нь, түүний үед хэрэгжүүлж байсан мөнгөний бодлогын мөн чанар дүрээ хувиргаагүй.

Ялгаа нь юу болж таарах вэ? Монголбанкны өнөөгийн удирдлагын хувьд өмнө нь ярьдаг хэрнээ хийж чаддаггүй байсан зүйлийг мэргэжлийн банкирийн хувьд, залуу хүний хувьд зоригтой барьж авахаар шийдсэнд байгаа юм. Төвбанкны түрүү түрүүчийн ерөнхийлөгч нарт дутагдаж байсан зүйл нь бэлэн мөнгө баруун солгойгүй тарааж, Монголбанкыг хүнд байдалд оруулаад, муу хэлүүлэх мянга түмэн шалтгааны үндсийг цэцэглүүлдэг Засгийн газартайгаа улаан нүүрээрээ учирч чаддаггүй байсанд л хамаг учир байсан хэрэг. Тэгвэл одоо Золжаргал ерөнхийлөгч мөнгө төгрөг гаргаж, тооцоо судалгаа хийх нь бидний ажил, яг газар дээр нь очиж хэрэгжүүлэх нь Засгийн газрын ажил. Та нарын үүрэг, оролцоо мөнгөний бодлогод асар чухал гэдгийг Засгийн газрын гишүүдэд биеэрээ төдийгүй бие төлөөлөгч нартайгаа хамт нэг бус удаа уулзаж ярилцаж, учирлажээ. Хэлэлцээрийн ширээний ард суухдаа айж мэгдэх биш, мэргэжлийн эдийн засагчийн авьяас ухааныг гаргаж, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг сайтар ярьж ойлгуулж, инфляцийг буулгаж иргэдийн амьдралыг сайжруулахын тулд ийм зүйл хиймээр байна. Үүнийг хийхийн тулд Монголбанкны оролцоо хаана нь байх уу, харин та нар юу хийх вэ гэдгийг сэтгүүлчдэд “хичээл” засан шигээ ой тойнд нь ортол ойлгуулж, зөвшилцөж яваа бололтой. Нэг үгээр хэлбэл, төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг Засгийн газар, Монголбанк өмнөх шигээ хоёр тийшээ харах биш, нэг ширээнд сууж чадсан гэсэн үг. Манай уншигчид санаж байгаа байх. Гадаад, дотоодод гайгүй сайн боловсрол эзэмшсэн хөгжилтэй орнуудын эдийн засгийг судалж, суралцсан залуухан эдийн засагч

нарын зарим нь энд тэндхийн хурал дээр “төсөв, мөнгөний бодлого нэг зүгт явах ёстой. Одоогийн манайх шиг нэг нь бэлэн мөнгө тарааж инфляцийг хөөрөгддөг, нөгөөх нь хумих бодлого барьж явж таарахгүй” гэж учирладаг. Золжаргал ерөнхийлөгч ч үүнийг мэдэж байсан учраас зоримог хийхээр зориг шулууджээ. Энэ талаар түүний юу ярихыг сонсьё. “Өнөөдрийг хүртэл мөнгөний бодлого нийт бий болсон мөнгийг зээл болгохгүй шиг яаж Монголбанкны үнэт цаасан дээр бариад байх вэ гэж л ирсэн. Энэ зөв. Буруу юм байхгүй. Гэтэл нөгөө талд махны нийлүүлэлт хэвийн биш, гурилын импорт зогсдог, татвар тавьдаг, үнэ нь үсэрч харайдаг. Замын Үүд дээр өргөн хэрэглээний бараа гацдаг. Энэ болгон нийлүүлэлтийн талын замбараагүй байдалтай холбоотой. Замбараагүй нийлүүлэлтээс зах зээл хамгийн дээр байгаа үнээ л аваад яваад байна шүү дээ. Доошоо орохоор нь худалдаа наймаа эрхлэгчид ашиг гээд халаасалчихаж байна. Ийм бодитой шалтгаанаар бий болж байгаа нийлүүлэлтийн инфляцийг Төвбанк дангаараа хэчнээн хичээгээд ч бууруулж чадахгүй. Засгийн газар энэ тал дээр ажиллах ёстой. Тиймээс л салбар салбараар нь мөнгөний бодлого дээр Засгийн газартай нийлүүлэлтийн талд тулж ажиллахыг зорьж байна. Миний бие Монголбанкны ерөнхийлөгчийн ажил авсанаас хойших арваад хоногийн хугацаанд /2012.10.02/ холбогдох яамдынхантай 20-иод удаа уулзалт хийлээ, багтайгаа очиж. Ойлголцож, зөвшилцөж байгаа. Ойлголцоно гэдэг бол маш чухал” гэв.

Ийнхүү инфляцийг нам түвшинд барина гэсэн зорилгынхоо үүднээс инфляцид ахиу жин дардаг бараа бүтээгдэхүүн тус бүрийг задалж ярьж, шаардлагатай зохицуулалтыг хийхэд Засгийн газрын оролцоог бий болгож, дэмжлэг авч байгаа нь Төвбанкны шинэхэн ерөнхийлөгчийн бодлогын онцлог юм. Тухайлбал, шатахуун дээр л гэхэд Монголбанкны зүгээс нийгмийн дундаж давхаргын хэтэвчийг нь байнга тэмтэрч байдаг жижиглэнгийн худалдаан дээр Засгийн газар хяналт шалгалт хий. Энэ чиглэлээр хамтарч хөтөлбөр ►►



► боловсруулъя гэдэг санал тавьсан байх жишээтэй. Мөн Монголд өргөн хэрэглээний барааны үнэ өсөхөд нөлөөлдөг нэг гол хүчин зүйл бол тээврийн зардал байдаг. Тиймээс Замын Үүдээр өргөн хэрэглээний бараа Улаанбаатарт орж ирэхэд тарифинд нь яг юу нөлөөлөөд байна вэ гэдгийг гаргаж тавьж, ярилцжээ. Энэ бол манайд анхаарал хандуулах асуудал болоод ужгирч буй сэдэв. Замын Үүд боомт нь сардаа 250 мянган тонн ачаа дамжин өнгөрүүлэх хүчин чадалтай гэдэг. Оюутолгойн барилгын материал байнга орж ирнэ. Дээр нь хавар барилгын улирал эхлэх үеэр цемент, будагнаас авахуулаад барилгын материалын импорт эрс нэмэгдэх үед дээрх боомтын өргөн хэрэглээний бараа орж ирэх суваг улам л нарийсдаг. Бараагаа оруулж ирэхийн тулд наймаачид танил тал, арын хаалга, авлига хээл хахуул өгнө. Тэд төлөвлөөгүй зардлаа барааны борлуулах үнэд шингээж л таараа. Дөрвөн жилийн өмнө Эрээнээс Улаанбаатарт ирж байгаа барааны 11 хувийг тээврийн зардал эзэлдэг

байсан бол өнөөдөр 25 хувь болж нэмэгджээ. Энэ бол маш таагүй зүйл гэдгийг Монголбанкныхан хэлж байна. Учир нь, суурь инфляцид том нөлөө үзүүлдэг гэсэн үг. Энэ чиглэлээр Монголбанк Засгийн газартай тусгай хөтөлбөр боловсруулахаар ярьж байгаа аж. Одоогоор Монголбанк, Засгийн газар мөнгөний бодлогын чиглэлээр хамтран хэрэгжүүлэх 4-5 төсөл бэлэн болоод буй гэнэ.

Золжаргалын зоригийг үнэлэе

“Та маш зоримог, зоригтой ажиллаж байгаа юм байна. Гэхдээ инфляцийг нэг оронтой тоо руу оруулах зорилго чинь биелэхгүй байх вий гэж айж байна уу. Яагаад гэвэл шинэчлэлийн Засгийн газар хүүхэд болгонд сар бүр 20 мянган төгрөг өгөхөөс гадна, өмнөх Засгийн газрын үед олгож байсан Хүний хөгжлийн 21 мянга, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сая төгрөгийн үлдэгдлийг гүйцээж олгоно гээд халамжийн хавтгайрлыг

дорвитой хумьж чадахгүй юм шиг байна. Гэтэл эдийн засгийн нөхцөл байдал тааламжгүй болж эхэлж байна. Ийм үед амаргүй зорилт дэвшүүлсэн юм биш үү? гэсэн сэтгүүлчийн асуултад Монголбанкны ерөнхийлөгч “Болгоомжлол бол байна. Нийт эдийн засгийн 50 хувь нь улсын төсөв шүү дээ. Аюулын нөлөөтэй хүмүүс. Гэхдээ хамтран ажиллах зөвшилцөл, хэлцлүүдэд багтайгаа сууж томъёолсон мөнгөний бодлогод итгэж байна. Бид макро эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институциудыг бэхжүүлэх гээд тодорхой зүйлүүдийг гаргаж тавьсан байгаа. Макро эдийн засгийн тогтвортой байдал гэдэг нь төсвийн мөчлөг дагасан халамжид дулдуйтсан бодлогыг болио гэсэн үг. Миний хувьд тодорхой нэг зүйл бол чинээлэг дундаж давхарга байж эдийн засаг урт хугацаанд тогтвортой өсдөг гэдэгт итгэдэг. Тийм болохоор зорьсон зорилгодоо хүрэхийн төлөө ажиллана. Тэгэхгүй юм бол ажиллахын хэрэг юу байна” ►►

► хэмээн итгэл дүүрэн хариулсан. Түүний итгэл, зоригийг үнэлъе.

Монголбанкны ерөнхийлөгчийн хувьд инфляци гэдэг эвлэрч болохгүй аюулт дайсан гэж үзэж байна. Чинээлэг дундаж давхарга, чадварлаг хүний нөөц, макро эдийн засгийн зохистой бодлого, төрөлжсөн эдийн засаг, хууль хэрэгжилт тунгалага байхыг Монголбанкны мөнгөний бодлого хүсэж байгаа аж. Гэтэл Монголын нийгмийн дундаж давхаргын амьдрал дэндүү сул байгаад Золжаргал ерөнхийлөгчийн санаа зовиож буй юм. Тиймээс дундаж давхаргыг чинээлэг болгоход ирэх оны мөнгөний бодлого чиглэжээ. Өнгөрсөн хугацаанд инфляци өндөр

байж, уул уурхайгаас орж ирсэн мөнгийг хавтгайрсан халамж болгон тарааж ирсэн нь ийнхүү эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг “биедээ нааж” байх ёстой дундаж давхаргынхныг дарласанаж. Төвбанкны судалгаанаас үзэхэд инфляци 10 гаруй хувьтай болоход нэн ядуу иргэдийн нуруун дээр 82 хувийн, дундаж орлоготой иргэдэд 35-50 хувийн үнийн дарамт үзүүлдэг байна. Гэтэл баян иргэдэд дээрх инфляцийн дарамт нэг хувийн ч нөлөө үзүүлддэггүй гэнэ. Түүнчлэн өнөөдрийн 15 хувийн инфляци ямар өртөгтэй болохыг илтгэх бяцхан тооцоо хийгээд үзье. Монгол улсын мөнгөний хэмжээг долоон их наяд төгрөг гэж бодоход

жилд 15 хувийн инфляцитай байна гэж тооцоход ганцхан жилийн дотор ард түмний халааснаас нэг их наяд төгрөг зүгээр л салхинд хийсчихэж байгаа аж. Хайран мөнгө. Тиймээс л Монголбанкны хувьд инфляцитай хөөцөлдөхөөс аргагүй байдаг гэнэ. Инфляциас болж ард түмний халааснаас салхинд хийсчихэж байгаа тэр их мөнгөний ядаж тал хувийг нь, болж өгвөл түүнээс доошоо оруулах нь Төвбанкны зорилго. Тиймээс 2013 оны мөнгөний бодлого дотор зоригтой найм гэдэг тоог тавьж өгчээ. Энэ зорилго биелсэн цагт зээлийн хүү буурч улмаар бизнесийн идвэхжилт сайжирна гэж үзэж байна. ■

ТӨСӨВ

БАЯН ТӨСВИЙН БАЛАГ НЬ ХААНА БОЛ

Б.БАЯРТГОХ

...Харамсалтай нь манай гишүүд төсвийн төслийг амин хувийн төсөв гэж андуураад зарлагаа хэтрүүлж, орлогоо дэндүү ихээр мөрөөдөх нь алдагдал хүлээх үндэс болдог...

Төсвийн өндөр тоог тойрсон хүлээлт, мэтгэлцээн, гайхашрал бий болов. Монголын урдаа барьдаг гэж хэлж болох эдийн засагчдын зарим нь ирэх оны төсвийн орлого, зарлагыг

сонсоод мэл гайхлаа. Тэд ийм төсвийн төсөл “зохиосон” Сангийн яамыг муулсангүй. Тийм төсвийг батлахаар хэлэлцэж буй УИХ-ын дархан эрхтэй гишүүдэд гомдсонгүй. Дохиолж буй хямралын сүүдэр Монголын эдийн засгийг хэрхэн нөлөөлөх бол гэдгээс л болгоомжилж сууна. Ямартөсөв Сангийн яамнынхан зохиосон нь ирэх өдрүүдэд Намрын чуулганаас илүү тодорхой болно. УИХ-ын гишүүдийн цөөнгүй хэсэг шинээр “төсөвчин” болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, тэдний олонх төсөв батлах, түүнийг унших, ойлгох, үр дүнг авч хэлэлцэх “анхны хичээлдээ” сууж байгаа нь энэ. Мэдээж шинэхэн гишүүдэд тоон дунд төөрөх, будилах, эс ойлгох гээд багагүй бэрхшээл гарна. Түүнээсээ ч суралцан, дараа дараагийн төсвийн

хэлэлцүүлэгт тоогоор ярьж, тооноос тоог олох арга барилд гарших нь лавтай. Гэхдээ өрхийн төсвөө бус улсын төсвөө хэлэлцэж байгаа гэдэгт л хамаг учир бий. Харамсалтай нь манай гишүүд төсвийн төслийг амин хувийн төсөв гэж андуураад зарлагаа хэтрүүлж, орлогоо дэндүү ихээр мөрөөдөх нь алдагдал хүлээх үндэс болдог. Тухайлбал, энэ оны “Төсвийн алдагдал нэг их наяд төгрөгт хүрээд байна” гэж Сангийн сайд нь учирласан ч Засгийн газар үл тоов. Манайхаас хэд дахин хүчирхэг эдийн засагтай улс орнууд бүсээ чангалж, зарлагаа танаж, “ходоодоо” сойж байхад Монгол улс тэс хөндлөн тийчлэхээр шийджээ. Үүнийг ирэх оны төсвийн зарлага гэрчилнэ. Махийг хөдөлмөрлөсөн иргэдийнхээ татвараар шинэчлэлийн



Засгийн газар нь дураар дургих нь. Ирэх оны төсвийн хэчнээн хувийг хэнд зориулж, хэний төлөө хэдийг төлөх нь тун сонин. Цэцэрлэг, сургууль, эмнэлэг, зам барихад төсвийн хөрөнгө оруулалт чиглэх болов уу гэтэл төсвийн зарлагын 70 хувийг нь урсгал зардал “уж байна”. Үлдэж буй 30 хувьд сургуулийн засвар, сумын эмнэлэг, зам харгуй засварлах мөнгө нь багтаад ирэх оны төсөв уутныхаа ёроолыг гөвөх бололтой. Товчхондоо, ирэх оны төсөвт улс орны амьдралд хэрэгтэй, дорвитой бүтээн байгуулалт алга. Шинэ сургууль, цэцэрлэг, эмнэлэгт тун базаахгүй хөрөнгө очихоор төсөвлөжээ. Дахиад л ирэх намар хүүдээ сургууль, охиндоо цэцэрлэг хайх болох нь.

Аймаар орлого, бүр ч аймаар зарлага...


Төсвийн асуудал дээр өнгөрсөн хугацаанд хамгийн чухал нь орлого байсан бол одоо зарлага болоод байна. Төсвийн орлого бүрдэж өгөхгүй, Сангийн сайдыг зовоодог байсан цаг саяхан. Тэгвэл одоо олсон орлогоо хуваарилах гэж салбарын сайд нь няравын үүрэг гүйцэтгэх нь холгүй. Гэтэл Сангийн сайд нар нярав бус буяны байгууллага шиг загнах нь тэдний “имиж” болсон. Ирэх оны гарааны төсөв долоон их наяд төгрөгийн зарлагатай барианы зүг хөдөллөө. Төсөвт тонн эсийн үнийг 6328.9 ам.доллар, боловсруулсан нүүрсний үнэ тонн нь 131.5 ам.доллар байхаар тусгажээ. Айсуй төсвийн

орлого, зарлагын төсөөлөл урьдчилан харахад урьд өмнө байгаагүй тоон дүнтэй байх нь ээ. Магадгүй, Монголын эдийн засаг тэлж, улс хөгжиж буйн шинж байх. Орлого нь 7.88 их наяд төгрөгөөр тогтжээ. Нэгдсэн төсвийн алдагдал 360 тэрбум төгрөг бөгөөд ДНБ-ий хоёр хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шалгуурыг хангаж байгаа гэж Сангийн сайд Ч.Улаан онцоллоо.

Ёроолгүй хүсэл, хязгааргүй хэрэглээ

Жил жилийн улсын төсөв өөр өөрийн онцлогтой байдаг. Өнгөрсөн дөрвөн жилийн төсөв “Хүний хөгжил сан”-гийн 21 мянга, оюутны 70 мянгаар олны танил болж байв. Тэгвэл ирэх оны төсөв хоосон хэтэвчтэй ч өмнөх Засгийн газрын өглөгч аавын дүрийг үргэлжлүүлэх нь тодорхой болов. Дээр нь давхар “Хүүхдийн мөнгөөр”гоёх нь ээ. Товчхондоо “хайр халамж, энхийрлэл, эрхлүүлэлтийн цуглуулга” гэмээр хэт тэлсэн зарлагатай төсөвт монголчууд умбаж, шумбах бололтой.

Гэхдээ хязгааргүй зарлагыг хэмжээгүй эрх мэдлээр бус хуулиар халахаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг бараг хоёр жилийн өмнө баталсан. Уг хууль цагаа олж ирэх онд хэрэгжих гэж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн буулган дор Сангийн сайд нэгдсэн төсвийн тухай хуулийн төслөө УИХ-ын даргад өргөн



Эх сурвалж: Сангийн яам

барьсан. Эл үйл явдалтай зэрэгцэн Монголбанкны ерөнхийлөгч Төрөөс мөнгөний бодлогын талаар ирэх онд баримтлах үндсэн чиглэлийн төслөө УИХ-аар батлуулахаар зүтгүүлэв. Төсөв, мөнгөний бодлогоор ▶

▶ аравдугаар сар “амьсгална”. Орон нутгийн сонгуулийн “өнгөн” дээр Төсвийн хэлэлцүүлэг өрнөж таарах цаг хугацааны хязгаар үүсэв. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн тэлсэн, үйл ажиллагааны цар хүрээнд багагүй өөрчлөлт орсон нь ирэх оны төсвийн урсгал зардалд жин дарах аж. Төсвийн урсгал зардал таван их наяд төгрөгт дөхөж байна. Үлдэж буй хоёр их наяд нь хөрөнгө оруулалт гэсэн “дугуйтай”. Сангийн сайд Ч.Улаан “Ирэх оны төсвийг тусгай шаардлагуудыг хангаж боловсруулсан” гэж мэдэгдсэн ч дээрх онцлог нь хэлбэр төдий зүйл бололтой. Монгол улсын нийгэм, эдийн засгийг ирэх онд хөгжүүлэх төсвийг Парламент хэлэлцэж, алдаа оноог шүүн тунгаан авах гээхийн ухаанаар хандах цаг үе нь ирээд байна. Өнгөрсөн оны төсөв долоон их наяд төгрөгийн зарлагатайгаар анх чуулганаар орж, буцаж байсан түүхтэй. Тэгвэл ирэх оны төсвийн даруулга нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэж үзэж болох юм. Угаас төсвийн хамжааргагүй байдлыг цэгцлэхэд томоохон түлхэц болно гэсэн хүлээлт УИХ-д ч, Засгийн газарт ч бий. Тиймээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох, Төсвийн алдагдал ДНБ-ий хоёр хувиас хэтрэхгүй, эсвэл ашигтай байх, төсвийн зарлага ДНБ-ий 40 хувиас давахгүй байх гэсэн шаардлагыг ирэх оны төсөвт мөрдүүлэх учиртай.

Дахиад л өсөлтийн жил тохиох уу

Тохионогэж Сангийн яамныхан хэлж байна. Оюутолгой зэс-алтны ордын үйлдвэрлэл ирэх онд эхлэхээс гадна “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрсний олборлолт хоёр дахин нэмэгдэх гэнэ. Мөн нийт нүүрсний олборлолт ирэх онд өсөх тооцоо гарсныг төсвийн төсөлд онцлон тэмдэглэжээ. Мөн төмрийн хүдрийн олборлолт ирэх онд 23.3 хувь, газрын тосны олборлолт 0.6 хувиар тус тус өснө гэсэн “мэргэ төлөг” буусныг төсвийн төсөл дуулгалаа. Энэ нь уул уурхайн салбараас олох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ

гэж үзэж зарлагаа долоон их наяд төгрөгөөр давуулжээ. Түүнчлэн газар тариалангийн салбар ирэх оны төсвийн төсөлд чамгүй орлого төвлөрүүлэх бол боловсруулах үйлдвэрлэл 12.3 хувиар өссөн дүнтэй гарах аж. Дэлхий нийтээр ярьж буй эдийн засгийн хямрал улсын нэгдсэн төсөвт нөлөөлж, шалихгүй гэнэ. Европын өрийн хямрал ужгирсан, Хятадын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт удааширсан нь Монголын эдийн засагт сүүдэрлэхгүй гэж зарлагаа “цадиггүй” тооцсон гэдгээ Сангийн яамныхан ч нуусангүй. Энэ оны төсвийн орлого саарч байхад ирэх оны төсвийн орлого хэрхэн бүтэхийг хэлж мэдэх хүн олдсонгүй. “Төсөвт бүрдэх татварын орлого саарч эхэлсэн. Өнгөрсөн жил нийт татварын орлогын 56 хувийг уул уурхайн салбар дангаар нийлүүлсэн. Энэ жил 60 хүртэлх хувийн орлогыг тус салбараас бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч хангаж чадахгүй нь” гэж МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, судлаач Б.Эрдэнэбат ярьсан юм. Энэ оны төсвийн орлого сох дутсаар. Тэгвэл ирэх онд манай улсын ДНБ-ий хэмжээ 18.5 хувиар өсч, нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 17.6 их наяд төгрөгт хүрэх өөдрөг төсөөлөл гарчээ. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээлд ирэх онд буурахаар байгаа боловч зэс болон алтны үнэ тогтвортой байх хандлагатай тул орлого тасрахгүй гэж төсвийн төсөлд тэмдэглэжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээнд төсвөөс гадуурх зардал нэмэгдэх эрсдэл өндөр байгаа аж. Үүнд, Концессийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүд болон Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх хөгжлийн баримжаатай төсөл, хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой төсвийн хөрөнгийн зардал эрс нэмэгдэх эрсдэлтэй гэж Монголбанкнаас сануулсан ч Засгийн газар тоох шинжгүй, “том аавын цээж” гаргасаар. Урьд өмнө хэзээ ч хэлэлцэж байгаагүй үлэмж цараатай төсөвт УИХ-ын гишүүд сүрдэх вий. Хөгжлийн банкнаас таван тэрбум ам.долларын үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалах саналыг УИХ-д хүргүүлэхээр зэхсэн нь урт хугацаанд төсвийн дарамт үүсгэж, өрийн сүлжээ өргөсөх эрсдэлтэйг



учир мэдэх хүмүүс тэмдэглэж байна. “Ямар ч зарцуулалтын төлөвлөгөө байхгүйгээр ийм их хэмжээний бонд зарах гэж байгааг Олон улсын валютын сан, Дэлхийн банк “аюултай алхам” гэж анхааруулж байна. Манайх ч мөнгөжсөнөөсөө хойш тэднийг тоохоо байсан даа” гэж нийтлэлч Б.Баабар бичжээ.

Эрсдэл энүүхэнд

Уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, борлуулалтыг өөдрөгөөр төсөөлсөн ирэх оны төсвийн орлогод Оюутолгой төслийн хувь нэмэр өндөр байх аж. Улсын төсөвт уул уурхайн салбар дангаар нэг их наяд 257 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж чадна гэдэгт Сангийн яамныхан ихэд найдаж байгаа гэв. Оюутолгой ▶



Фотог Б.Бямба-Очир

► компани ирэх онд 382 мянган тонн зэсийн баяжмал, 424 мянган тонн унци алт, 802 мянган тонн унци мөнгө олборлож, тус компани улсын төсөвт нийт 151 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээр төсөвт тооцсон нь орлого өсөхөд нөлөөлөх бөгөөд дураар зарцуулах боломж олдох аж. Улмаар уул уурхайн салбар бараг л хоёр их наяд төгрөгийн орлого олох хар зураг гарчээ. Түүнчлэн Тогтворжуулалтын санд нийтдээ 169.76 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байгаагийн 103.8 тэрбум төгрөг буюу 61 хувь нь зэс, 66 тэрбум төгрөг нь нүүрснээс бүрдэх аж. Сангийн яамны халаасанд буй Татварын ерөнхий газар төсөвт гурван их наяд төгрөгийн орлого бүрдүүлэх бол Гаалийн ерөнхий газар дангаар хоёр их наяд төгрөг төвлөрүүлэх үүргийг хүлээх аж. Үндсэндээ татвар болон

гааль ирэх оны нэгдсэн төсвийн нийт орлогын 75.8 хувийг бүрдүүлэх үүрэг авах бололтой.

“Төсвийн мэдээлэл татвар төлөгчдөд нээлттэй ил тод, хүртээмжтэй байх ёстой. Түүнчлэн төсвийн баланс тэнцвэртэй байснаар эдийн засагт илүү өгөөжтэй. Манайх улс төрийн эрх ашгийг хойш тавиад аль болох л төсвийн зарлагаа хэмнэх хэрэгтэй. Болд, Нараагаас мөнгө зээлнэ гээд амьдраад байж болохгүй шүү дээ. Эргээд яаж төлөх вэ гэдгээ сайтар бодох учиртай. Манайд энэ бодлого үгүйлэгдэж байна. Өр тавиад авч буй зээлээ үр ашигтай зүйлд бус урсгал зардал, халамжинд зарцуулж байгаа нь тун харамсалтай хэрэг. Зөвхөн зорилтот бүлэгт л халамж түгээх хэрэгтэй. Үүнийгээ улстөрчид нь мэддэг боловч хүсэхгүй байна. Эрсдэлийг нь мэдсээр байж популист

бодлого хэрэгжүүлж өрөөсөө болохгүй” хэмээн Нээлттэй нийгэм форумын Эдийн засгийн асуудал хариуцсан менежер Б.Мөнхсоёл онцоллоо.

Төсвийн хөрөнгө оруулалтаас дурдахад, Нийслэлийн агаарын бохирдолыг бууруулахад 9.4 тэрбум төгрөгийг зөвхөн утаанд зориулахаар болсон байна. Тэгвэл ирэх оны төсвийн нийт хөрөнгө оруулалтын 44.4 хувийг дэд бүтцийн салбарт, 24.4 хувийг боловсрол, соёл, эрүүл мэнд, хүний хөгжилд зарцуулахаар төсөлд тусгажээ. Үлдэж буй 32 хувийг хөдөө аж ахуй, үйлдвэрлэл болон бусад салбарт олгохоор тусгажээ. “Монгол улс хямралын төсвөө хэлэлцэж байна” гэж олон улсын санхүүгийн байгууллагууд болгоомжилсоор. Ёроолгүй хүсэлтэй, хязгааргүй зарлагатай Монгол улсын ирэх оны төсөв ямархан ирээдүйг зөгнөнө вэ... ■

ЦООРХОЙ ХАЛААС

“ЦАЛИНТАЙ” ХҮҮХДҮҮД

Э.ЗОРИГТ

...“Хэрвээ эцэг эх болгон хүүхдийн мөнгөө аваад хугацаатай хадгаламжид хийвэл энэ бол таны хүүхдийнхээ ирээдүйд хийж буй хөрөнгө оруулалт. Харин бэлнээр аваад дэлгүүр орвол мөнөөх л инфляци өсөх үндэс болж магадгүй”...

“Төрөөс олгох хүүхдийн мөнгийг манай банкны салбарууд болон АТМ-ээс хураамжгүй авах боломжтой тул Та өөрт ойр байрлах манай салбарт ирж бүртгүүлээрэй” гэх мэссэжийг арилжааны банкууд уралдан нисгэх болов. Хүүхдийн мөнгөө авахаар хүлээж суугаа эцэг эхчүүд ч энэ сургаар цахим үнэмлэх, хүүхдийнхээ төрсний гэрчилгээг цүнхлэн таалалд нийцсэн банкныхаа зүг алхална. Товчхондоо хүүхдийн мөнгө олгоход төрөөс хийх ажил цэгцэрчихсэн гэх. Гэвч эдийн засагчид хүүхдийн гэх тодотголтой 20 мянган төгрөгийг бяцхан үрсийн ирээдүйд хийж байгаа хөрөнгө оруулалт гэж үзвэл буруутгаж боломгүй. Гэхдээ уг мөнгө эзэндээ биш ээж, аавын халаасанд очвол юу болох вэ гэдгийг төр, засаг бодох л асуудал гэдгийг сануулж байсан.

Хүүхдийн мөнгө тараах шийдвэрийг АН гаргахдаа “Хүүхдийн мөнгийг олгох нь зөв үү, эсвэл буруу юу” гэх судалгаа явуулахад хөдөөгийнхний 92.8 хувь, нийслэлчүүдийн 81.7 хувь нь “Хүүхдийн мөнгө олгох нь зөв” гэж хариулсан байсан. Харин хүүхдийн мөнгө олгох нь огт буруу гэж ердөө

таван хувь нь хариулсан аж. Хөдөө, хотын дунджийг аваад үзэхээр санал асуулгад оролцогчдын 87 хувь нь хүүхдийн мөнгө авах нь зөв гэсэн учраас дээрх шийдвэрийг гаргасан байна. Гэхдээ энэ судалгаа хүүхдийн мөнгө өгөх нь зүйтэй гэх бус харин Монголын ард иргэдийн 90 орчим хувьд нь 20 мянган төгрөг ямар их хэрэгтэй байгааг харуулж байх шиг. Санхүү эдийн засгийн дээд сургуулийн судлаач, багш З.Оюунцацрал “Хүүхдийн ирээдүйд хөрөнгө оруулах нь зөв. Гэхдээ энэ удаагийн шийдвэрийн мөнгө олгох механизм нь буруу байх шиг. Хэрвээ манай эцэг эхчүүд бүгд хүүхдийн мөнгөө аваад хадгаламжийн дансанд хийвэл энэ бол хүүхдийнхээ ирээдүйд хийж буй хөрөнгө оруулалт. Гэтэл бэлнээр аваад дэлгүүр орвол мөнөөх л яригддаг үнийн хөөрөгдөл болж магадгүй. Гэхдээ хүн бүрт олгох 21 мянга, хүүхэд бүрт өгөх 20 мянган эдийн засаг дахь сөрөг нөлөөллийн хувьд өөр” гэв. Гаднын ихэнх оронд улс орныхоо ирээдүй болсон хүүхэд багачуудад мөнгө олгодог тогтолцоо бий. Тэгэхдээ ихээхэн ухаалаг бодлого хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, Сингапурын Ерөнхий

сайд асан Ли Куан хоёр дахь хүүхдээ төрүүлсэн эхийн цалингаас нь авдаг зарим төрлийн татварыг чөлөөлөх, гурав дахь хүүхдээ төрүүлбэл нөхрийг нь давхар чөлөөлөх зэргээр гэр бүл салалтыг хүртэл төрөлттэй уяж шийдсэн байдаг байна. Энэ нь нэг талаар залуу гэр бүлийг дэмжээд зогсохгүй нийгэмд бэлэн мөнгө тараалаа гэх сөрөг ойлголт гарахгүй байх сайн талтай аж. Мөн ХБНГУ шинээр төрсөн хүүхдийн нэр дээр зөвхөн дансны эзэн нь насанд хүрсэн хойноо захиран зарцуулах боломжтой данс нээж улсын төсвөөс нь тодорхой мөнгийг хуримтлуулдаг байна. Харин манай Засгийн газар хүн бүрт хүүхдийн мөнгөө авахгүй байж болох сонголтыг үлдээж байгаа гэнэ. Нийт хүүхдийн тал хувь нь мөнгөө авахгүй бол улсын дансанд 130 орчим тэрбум төгрөг гарч ирэх бөгөөд тэр мөнгөөр улс өдгөө зайлшгүй шаардлагатай байгаа цэцэрлэг, сургуулийн тоог нэмэх юм байх. Одоогоор 100 ортой нэг цэцэрлэгийг 500-600 сая төгрөгт багтаан барьж байгаа аж. Харин улстөрчдийн энэ мэт гаргалгааг эдийн засагчид болоод судлаачид эгдүүцэж байгаагаа нуугаагүй юм. Учир нь төр хүссэн ч хүсээгүй ч ард иргэдийнхээ сурч боловсрох, эрүүл аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Төр угтаа үйлчилгээний байгууллага шүү дээ. Түүнээс биш, ард түмэн мөнгө авахгүй бол төр цэцэрлэг, сургууль байгуулна. Үгүй бол чадахгүй гээд суух нь ичгэвтэр хэрэг юм. Оюунцацрал судлаач “Хүүхэд бүрт 20 мянган төгрөг бэлнээр олгох нь үр ашиггүй. Гэхдээ бэлнээр ▶

Хүүхдийн мөнгөний мөрөөр...



Шог зургийг А.Амарсайхан

12

► авахыг нь хориглож болохгүй байх. Тийм учраас иргэдэд сонголтыг нь үлдээх хэрэгтэй. Тухайлбал, бэлнээр авах, хадгаламжийн дансанд урт хугацаатай, өндөр хүүтэй хадгалуулах, цаашлаад боловсролын даатгалд хамрагдах гээд төрөл бүрийн арга байж болно” гэв. Харин хорих эсвэл асрамжийн газар байгаа хүүхдийн тухайд асран хамгаалагч, халамжлагч нь мөн гэсэн бичгийг харьяа хороо, сумын Засаг даргаас авч тухайн хүүхдийн нэр дээр данс нээлгэнэ. Гэхдээ тэдний нэр дээр харилцах биш хадгаламжийн данс нээж 16 нас

хүртэл нь өөр хэн ч захиран зарцуулах эрхгүйгээр хадгалах юм байна. Уг нь хүүхэд бүрийн мөнгийг харилцах биш хадгаламжийн дансанд өндөр хүүтэй төвлөрүүлбэл Монголын үрс маш олон болохыг дэмжсэн төрийн бодлого зөв явах болов уу.

Хамгийн сүүлийн судалгаагаар ядуурлын түвшин 29.8 хувьтай байгаа дүн гарчээ. Энэ тоонд итгэхэд бэрх ч Монголд гурван хүн тутмын нэг нь ядуу гэдэг яахын аргагүй үнэн. Эдгээр ядуу иргэдэд 20 мянган төгрөг хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулна гэхээсээ илүү өнөө маргаашийн өл зогооход

зарцуулагдах нь тодорхой. Чингэлтэй дүүргийн иргэн Ч.Энхтөр “Манайх ам бүл тавуулаа. Эхнэр бид хоёрын сарын цалин нийтдээ нэг сая гаруй төгрөг болдог. Гэхдээ л улсаас өгдөг 21 мянган төгрөг хэрэг болоод л байсан. Ирэх сараас өгөх 20 мянган төгрөг ч мөн адил цахилгааны мөнгөнд нэмэр болох л байх” гэсэн юм. Сарын сая төгрөгийн орлоготой нийгмийн дундаж давхаргын төлөөлөл гэр бүл ийн ярьж байна. Мөн өнөөгийн нийгэмд хүүхдийнхээ мөнгөөр архи аваад уучихаж мэдэх барьцгүй эцэг эх, гэр бүл цөөнгүй байгаа нь нууц биш. ■

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

“ТАНАЙ УЛСАД АЗИЙН ХАМГИЙН АМЖИЛТТАЙ ЯВАА ХОЁР ГРУПП ХӨРӨНГӨ ОРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ”

Б.ЭНХЦЭЦЭГ

Анх гуравхан хүнтэйгээр үйл ажиллагаагаа эхэлж байсан “Хүннү коал” компани гуравхан жилийн дотор Монголын ашигт малтмалын салбарт томоохон байр суурь эзлэх болсоноос гадна энэ хугацаанд Австралийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийсэн билээ. Мөнтэд Азийн тэргүүлэгч хөрөнгө оруулагч групп болох “Банпу” болон “Липпо” компанийг Монголын ашигт малтмалын

салбарт татан оруулсан гавьяатай. Манай сэтгүүл энэ удаад “Хүннү коал” компанийн ерөнхий захирал Т.Лхагвадорж болон “Гаррисон капитал” компанийн ерөнхий захирал Матью Вүүд нартай Монголын ашигт малтмалын салбарын өнөөгийн байдал, цаашдын хандлагын талаар ярилцсанаа хүргэж байна.



Зүүн гар талаас “Гаррисон капитал” компанийн ерөнхий захирал Матью Вүүд, “Хүннү коал” компанийн ерөнхий захирал Т.Лхагвадорж

Фотог Э.Зоригт

...Одоо бүгд л наашаа хараад хэрэв “Бангу”, “Липпо” хоёр хөрөнгө оруулж байгаа юм бол Монгол улс хөрөнгө оруулахад таатай газар байж таарна гэж бодож суугаа...

-Сонгуулийн өмнө батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль хөрөнгө оруулагчид тэр дундаа уул уурхайн салбарынханд ойлгомжгүй байдлыг бий болгосон гэж яригдаж байгаа. Шинэ Засгийн газар тус хуульд өөрчлөлт оруулах эсэх нь тодорхойгүй байгаа өнөө үед Та уг хуулийн талаарх саналаа хуваалцахгүй юу?

Матт: Хууль хэрхэн хэрэгжихийг л харж сууна даа. Монгол улс Хөрөнгө оруулалтын зөвлөлтэй болох нь чухал байна. Монгол шиг стратегийн ач холбогдолтой нөөцүүдээ хамгаалахыг зорьдог улс орнууд зөвлөлтэй байдаг. Түүний нэг жишээ нь Австрали. Зөвлөлтэй болох нь чухал ч хэрэгжилтийг нь хэрхэн хангах вэ гэдэг асуудал түүнээс илүү чухал. Аливаа нэг зөвшөөрөл, лиценз олгохын тулд зургаан сар, нэг жил эсвэл түүнээс ч урт хугацаанд шийдвэрээ гаргахгүй уддаг хүнд сурталтнуудтай болох нь Монгол улсын хувьд хүсэх зүйл биш. Бүх ажил хэрэг тэр хэмжээнд сунжирна л гэсэн үг. Харин энэ улс орны эдийн засгийн хурдацтай хөгжил, үндэсний эрх ашгийг хүндэтгэн ажлаа явуулбал томоохон эерэг нөлөөлөл байх болов уу.

-Хөрөнгө оруулагчдын олонх нь тань шиг бодолтой байгаа гэж Та бодож байна уу ?

-Монгол улс бол сонголтуудын нэг. “Гаррисон капитал” нь дэлхий даяар үйл ажиллагаагаа явуулдаг компани. Хэрэв хөрөнгө оруулалтын хууль ашиггүй нөхцөл байдал үүсгэвэл өөр аль нэг улсад хөрөнгө оруулалтын илүү таатай орчинг харж эхлэх нь дамжиггүй. Бусад хөрөнгө оруулагчдын хувьд санаа бодол нэгтэй байгаа байх. Бидэнд тоглоомын талбай тэгшхэн байх

нь таалагддаг. Тоглолтын дундаас дүрэм нь өөрчлөгдөөд байхыг хүсэхгүй. Би Монголд ирж ажиллаад гурван жил гаруй болж байна. Бид чамлахааргүй ч амжилтыг үзүүлсэн. Тиймээс “Гаррисон” Монголд удаан хугацаанд үйл ажиллагаа явуулах сонирхолтой байгаа. Бизнесийн олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг боллоо. Одоогоор бид үндсэн болон үндсэн биш 1000 гаруй ажилтантай. Ажил хэрэг бүтэмжтэй сайн яваа. Түүндээ ч урамшиж байгаа. Гэвч дахин шинээр хууль гарч ирээд эсвэл өөрчлөгдөж биднийг тухгүйтүүлээд байхыг хүсэхгүй байна.

-Гадаадын хөрөнгө оруулалтын тухай шинэ хуулийг экспортыг дэмжсэн салбарын эдийн засгийн аюулгүй байдалд халдсан хэрэг гэж хатуухан шүүмжлэх хүн ч байдаг. Энэ хууль тухайлбал, танай компанийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байна вэ. Энэ хуулийн талаарх салбарынхны бодол юу байдаг вэ?

Т.Лхагвадорж: Ер нь бол манай салбарынхны хувьд дээр хэлсэнчлэн хөрөнгө оруулалтын Зөвлөлтэй байх нь зөв гэж олонх нь үзэж байгаа. Түүнийг хэрэгжүүлэх механизм нь ил тод, асуудлыг үнэн зөв шуурхай шийддэг систем хэрэгтэй байна. Одоогийнх шиг журам нь ч батлагдаагүй бүрхэг, ойлгомжгүй хуулийг хүн болгон дур дураараа орчуулна шүү дээ. Ингэхээр мессеж хөрөнгө оруулагчдад ямар ч байдлаар очиж болно. Ерөөсөө 49 хувийн хөрөнгө оруулалт хийж болох агаад түүнээс илүү хөрөнгө оруулалтын боломж байхгүй юм байна гэж ойлгох юм бол энэ үнэхээр асуудал. Асуудлыг хэд хоногт яаж шийдэх вэ гэсэн нарийн зохицуулалт бүхий тодорхой механизм байх л хэрэгтэй.

-Та Австралид Зөвлөлөөрөө дамжуулан хуулийн хэрэгжилтээ хянадаг тухай хэллээ. Тэгвэл энэ хоёр орны Хөрөнгө оруулалтын тухай хууль юугаараа ялгаатай вэ?

Матт: Би хуулийн мэргэжилтэн биш л дээ. Гэхдээ Австралид тодорхой мөнгөн дүнгээс /200 сая ам.доллар гэж бодож байна/ давсан хөрөнгө оруулалт хийж буй гадаадын аж ахуйн нэгж 15 хувиас дээш

өмчлөлийн эрх авах хүсэлтэй байгаа бол Хөрөнгө оруулалтын зөвлөл зөвшөөрөл өгөх ёстой байдаг. Тухайн зөвшөөрлийг олгох ажил зургаан сар бус 30 хоногт л үргэлжилдэг. Монгол 49 хувиас дээш гэж үздэг бол тэнд 15 хувиар тогтоодог.

Нэг том ялгаа нь ажил хэрэг явуулах хурд юм. Энэ бүх асуудлыг шуурхай шийдвэрлэж байх нь чухал. Томоохон хөрөнгө оруулалт хийж байгаа хүмүүс асуудлыг одоо шийдвэрлэгдэх үү эсвэл зургаан сар хүлээх ёстой юу гэдгийг тодорхой мэдэх хүсэлтэй байдаг. Товчхондоо, хэрэгжилтийн талд гол учир нь байгаа юм. Хоёрдугаарт, өмчлөлийн асуудал байна. Австралид стратегийн ач холбогдол бүхий зарим нөөцийн тухайд зөвлөл “Үгүй ээ, бид энэ зөвшөөрлийг олгохгүй” гэж хэлэх тохиолдол байдаг ч энэ нь ховор. Зөвшөөрөл өгөөгүй нөөц Австралийн аж ахуй нэгжийн гарт хадгалагдаж байх ёстой. Бид тухайн стратегийн ач холбогдолтой нөөцийг Хятад эсвэл Английн компани эзэмшээсэй гэж хүсэхгүй. Зөвлөлөөс Австрали улсын хувьд тухайн нөөц үнэхээр эдийн засгийн өндөр ач холбогдолтой нөөц мөн үү үгүй юу гэдгийг сайтар нягталсны эцэст шийдвэрээ гаргадаг.

Бусад тохиолдолд асуудал маш шуурхай шийдвэрлэгддэг. Австралид тодорхой нэг салбарын нөөц хөрөнгийн гадаад өмчлөл 50 хувиас хэтэрч болохгүй гэсэн зүйл огт байдаггүй. Ингээд ажил бүтэхгүй. Өөрөөр хэлбэл, хүмүүс хөрөнгө оруулахаа зогсоочихдог.

-Монголын уул уурхайн салбарын бодлого зохицуулалтыг Та хэрхэн дүгнэдэг вэ?

-Таалагдах, таалагдахгүй зүйл хоёулаа байгаа. Уул уурхайн салбар нь тэргүүлэх ач холбогдолтой орны хувьд лицензтэй холбоотой тогтолцоонд олон зүйлийг хийх шаардлагатай байдаг. Тухайлбал, манайх шиг компанийн хувьд шинээр хайгуулын лиценз авах боломжгүй. Энэ нь Монголд цаашид шинэ бүтээн байгуулалт, хайгуул явагдахгүй л гэсэн үг. Угаас зөвшөөрөл авангуутаа олборлоод эхэлнэ гэж байхгүй. Лиценз авсан ч олборлолт хийхээс өмнө олон жилийн хайгуулын ажил хийх шаардлагатай байдаг. ▶

Одоо хуучин лицензийн ихэнхийнх нь хугацаа дуусч байгаа. Монголын газрын зураг дээр 2005 оноос өдийг хүртэлх хугацаанд олгосон лицензийг харвал тоо нь эрс буурсан байгааг харж болно. Би үүнийг Монгол улсын хувьд ашигтай нөхцөл байдал гэж бодохгүй байна. Энэ бол улсын хэмжээнд ихээхэн хохиролтой асуудал.

Лхагвадорж: Хайгуулын шатандаа явж буй төслүүд бүгд уул уурхайн олборлолт болж хувирдаг гэж ойлгож огт болохгүй. Орд газар оллоо ч энэ нь олборлолт эхлэх хэмжээний эдийн засгийн үр ашигтай байна гэсэн үг биш. Олборлолтын шатанд хүрэхийн тулд наана нь тухайн төсөл эдийн засгийн үнэ цэнэтэй байж чадах эсэхийг үнэлж дүгнэсэн зах зээл, шинж чанар болон агууламжийн судалгаа, үнэлэлт гэх мэт маш олон ажлыг хийх хэрэгтэй байдаг. Бүтэн есөн жилийг хайгуулд зориулсан ч эцэст нь олборлолт хийх боломжгүйг олж тогтоох нь ч бий. Магадгүй, 20 эсвэл 50 жилийн дараа геологи, зах зээл болон байгаль орчны нөхцөл байдлаас үүдэн шинэ төсөл хайх шаардлага ч гарч ирж болно. Эцэст нь, тухайн оронд шинээр төсөл хөтөлбөр хэрэгжих боломжгүй болоход бүгд орхиод явдаг. Учир нь тэнд үлдэнэ гэдэг дэндүү эрсдэлтэй асуудал.

Засгийн газар тийм их зүйл хийгээд байх шаардлагагүй гэж би боддог. Тэдний зүгээс зөвхөн бодлого чиглэлээ тодорхой болгож, хэрэгжилтийг нь хангаад явахад л болно. Аливаа бодлогыг танилцуулснаас хойш тав, арван жилийн дараа үр нөлөө нь гардаг болохоос тэр дороо үр дүнгээ өгөөд эхлэх гэж байхгүй.

-Олон хөрөнгө оруулагч Европын өрийн хямрал, Хятадын эдийн засгийн удаашрал Монголыг дайрах вий гэдгээс ихээхэн болгоомжилж байх шиг байна. Та бүхний хувьд энэ нөхцөл байдлыг хэрхэн давж гарах талаар ямар төлөвлөгөөтэй байгаа вэ?

Матт: Бид алзахгүй ээ, эрдэс баялгийн салбарын нэг хэсэг нь уналт, өсөлт юм. Бүх насаараа энэ салбарт зүтгэж байгаа хүний хувьд өгсөж уруудах үе олон байдгийг хэлэх байна. Уруудах үед нь бизнес

төлөвлөгөөндөө ялимгүй өөрчлөлт оруулаад л үйл ажиллагаагаа хэвийн аваад явах хэрэгтэй. Бусад хүмүүс сандарч мэгдэж байхад таны хувьд эзэмшлээ ихэсгэж болох юм. Өөрөөр хэлбэл, хүн бүр зараад байвал, Та худалдаж авч байх хэрэгтэй. Аливаа зүйлд арай өөрөөр илүү ухаалаг хандаж, оролдоод үзэхэд гэмгүй.

Нөхцөл байдал таагүй үед хэрэв бусад хүмүүс бизнесийн үйл ажиллагаагаа хумьж, ажилтнуудаа цомхотгож эхэлбэл чамд чадвартай боловсон хүчин олж авах сайхан боломж гарч ирлээ гэсэн үг. Мэдлэг, туршлагатай мэргэжилтэн Монгол улсын хувьд томоохон асуудал болсоор байна. Монгол жижиг улс. Тиймээс тэр хэмжээнд боловсрол маш чухал үүрэгтэй. Иймд цөвүүн цаг чадварлаг боловсон хүчнээ зузаатгах тохиромжтой үе болж бас болдог. Цаг солигдож нөхцөл байдал дээрдэхэд хавьгүй илүү таатай байр суурин дээр очсон байх болно.

-Нүүрсний экспортын зогсонги байдлыг зарим хүн Хятад улс өөрийн хүчтэй нөлөөллөө өсгөх гэсэн оролдлого эсвэл Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийг үнэгүйдүүлэх гэсэн бас нэг мэх байх магадлалтай хэмээн хардаж байна. Тэгвэл таны хувьд энэ тухайд юу хэлэх вэ ?

-Хятадын эдийн засгийн удаашралд сүртэй ач холбогдол өгсөн зүйл надад алга. Миний бодлоор Хятадын өмнө маш том өсөлт бий. Тиймээс энэ удаагийн нөхцөл байдал ч тэр магадгүй тус улсын гаргадаг олон жижиг тоглолтуудын л нэг байх. Тухайлбал, төмрийн хүдрийн үнэ 140 ам.доллараас 85 болтлоо буурсан ч одоо эргээд 105 ам.доллар болчихсон явж байна. /2012.09.19/ Хүн бүр л “Өө, Хятадын эдийн засаг удааширч байгаа учраас тэр” гэгцгээж байсан. Гэвч зэсийн үнэд өөрчлөлт орсон зүйл байхгүй л байна шүү дээ. Зэсийн үнэ эдийн засгийн саармагжилтийг харуулахад харьцангуй нөлөө бүхий үзүүлэлт.

Эргээд 2009 оныг харвал тэр үед зэсийн үнэ дөрвөн ам. доллараас 1.30 ам доллар хүртэл навс унаж байсан. Тэр үе бол үнэхээр дэлхийг хамарсан эдийн засгийн бууралт байв. Одоогийн үүсээд байгаа нөхцөл байдал миний санааг огт зовоохгүй

байна.

-Нүүрсний зах зээл дэх таагүй байдал хэр удаан үргэлжилнэ гэж таамаглаж байна вэ?

-Үүнийг би түр зуурын бууралт гэж харж байгаа. Шинэ он гэхэд нүүрсний үнэ сэргэж эхлэхийг бид харна. Энд нэг зүйл тодорхой. Дэлхийн хүмүүс удаан хугацаанд нүүрс шатааж амьдрах нь илэрхий.

Лхагвадорж: -Монгол экспортын боломжит бусад зах зээлд хүрэхийн тулд Орос, Хятад гэсэн хоёр орноор дамжихаас өөр аргагүй. Манай хойт хөрш өөрөө нүүрсний тийм том хэрэглэгч биш. Харин Хятад, Солонгос болон Япон улс нь томоохон зах зээлтэй орон.

Дээрх орнуудад ашигтай зах зээл байгаа ба тэр дундаа коксжих нүүрсний хувьд ихээхэн боломж байгаа.

Матт: Хятадын хувьд хэдийгээр том гүрэн ч зарим хэсгийнх нь хөгжил удаашралтай байхад нөгөө хэсгийнх нь хөгжил маш хурдацтай явж байх жишээтэй. Сайн ажвал тус улсын Монголтой хил залгаа мужуудын хөгжил харьцангуй сайн байгаа. Тэдний хувьд хамгийн өндөр өсөлт, хэрэглээтэй байгаа юм. ▶





► **“Хүннү коал”, “Харанга ресурс”, “Вояжер ресурс” гэх мэт компанийг менежментийг авч яваа удирдлагын хувьд “Гаррисон капитал”-ын хариуцлагатай уул уурхайн тал дээр баримталдаг бодлого юу вэ?**

Лхагвадорж: Олон хүн хариуцлагатай уул уурхайн талаар ярьдаг. Манай компаниудын ихэнх нь хөрөнгийн зах дээр бүртгэлтэй байдаг учир бид зөвхөн уул уурхайн, олборлолтын хувьд бус хөрөнгө оруулагчдынхаа өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг давхар авч явдаг.

Биднийг компанийнхаа үйл ажиллагаанд хариуцлагагүй үйлдэл хийгээд суухыг хөрөнгө оруулагчид харахыг хүсэхгүй шүү дээ. Бид үйл ажиллагааныхаа тайланг улирал болон жилээр дэлхий дахинд нээлттэй танилцуулдаг. Бидний тухай мэдээлэл авахыг хүссэн хэн ч манай цахим хуудсанд ороод авчихаж болно. Компанийн зүгээс ямарваа нэг буруу зүйл хийж байгаа талаар хөрөнгө оруулагчид хардлага төрлөө гэхэд шууд асууж хариултаа авах боломжтой байдаг. Хөрөнгө оруулагч том, жижиг ямар байх нь хамаагүй тэд асуух, мэдэх эрхтэй.

Матт: Бид энэ салбарт олон жил

байлаа. Цаашид ч удаан хугацаанд байх болно. Тиймээс нэр хүндээ сэвтүүлэх зүйл хийхийг хүсдэггүй. Бидний маш их болгоомжилдог зүйл бол тэр.

“Хүннү коал”-ын амжилт, “Банпу”-тай хийсэн хэлцэл гэх мэт өнгөрсөн жил гаргасан амжилтыг тань бид харсан. Тэгвэл “Гаррисон капитал” компанийн дараагийн том алхам юу вэ?

-Хэдийгээр “Банпу” компани хамгийн том хувьцаа эзэмшигч ч гэлээ Жорж/Лхагвадорж/ бид хоёр “Хүннү коал”-ын үйл ажиллагаанд ихээхэн оролцоотой хэвээр байгаа. Бид “Банпу” компанийг нүүрсний бизнесээ гайхалтай амжилтад хүргээсэй хэмээн хүсэж байгаа учир одоо ч тусалж хамтран ажилладаг. Ингэснээр бид цаашид “Харанга ресурс”-ын төмрийн хүдэр, “Вояжер”-ийн зэс болон шинээр эхлүүлж буй газрын тосны “Вольф петролиум” компанийнхаа үйл ажиллагаанд анхаарлаа бүрэн хандуулах боломжтой болж ирж байгаа. Бид Монгол улсад удаан хугацаанд ажиллаж, амьдарна. Тийм учраас дээрх чиглэлүүд дээр удаан хугацааны зорилго тавин ажиллаж байна.

Лхагвадорж: -Азийн нүүрсний тэргүүлэгч компанийг Монголд оруулж ирсэн “Хүннү коал” компанийн амжилт зөвхөн бидний хувьд чухал бус улсын хэмжээнд томоохон ач холбогдолтой үйл явдал юм. Хэдийгээр “Банпу” компани Монголын хувьд тийм олонд танигдсан компани биш ч Индонез, Австрали, Хятад гэх мэт оронд хөрөнгө оруулалт хийдэг нэр хүндтэй томоохон уул уурхайн компани гэдгээрээ олон улсын тавцанд алдартай билээ. Гадаадын хөрөнгө оруулагчдад тэр дундаа томоохон хөрөнгө оруулагчид энэ нь Монголд хөрөнгө оруулж болно гэсэн дохио болж байгаа хэрэг. Энэ бол Монголын хувьд том амжилт.

Матт: -Азийн тэргүүлэгч конгломерат үйлдвэрлэгч компани болох “Липпо” группыг бид төмрийн хүдрийн бизнестээ татан оролцуулж чадсан. Тэдний хувьд манай төмрийн хүдрийн бизнесийн томоохон хувьцаа эзэмшигчээр орж ирж байгаа. Энэ нь Монголын хувьд бас нэг том амжилт. Танай улсад Азийн хамгийн амжилттай

яваа хоёр групп хөрөнгө оруулж эхэллээ. Энэ бол тод дохио. Одоо бүгд л наашаа хараад хэрэв “Банпу”, “Липпо” хоёр хөрөнгө оруулж байгаа юм бол Монгол улс хөрөнгө оруулахад таатай газар байж таарна гэж бодож суугаа.

Лхагвадорж: Манай компанийн гол амжилт бол Монгол менежментээ хадгалсаар байгаад оршино. Гадаадынхныг оруулж ирж, юу хийхээ заалгахаас илүүтэй гадаадын хөрөнгийн зах дээр монгол компани хувьцаа гаргаж, хөрөнгө татан ажиллах нь асуудалгүй, зөв арга юм гэдгийг бидний үйл ажиллагаа харуулж байгаа болов уу гэж бодож байна.

“Монголын уул уурхайн салбарын томоохон төлөөллүүдийн хувьд уул уурхайн хөгжилд тулгуурласан Монгол улсын хөгжлийн хандлагыг хэрхэн харж, таамаглаж байна вэ?”

Матт: Итгэмээргүй сайхан боломж байгаа гэж хэлмээр байна. Үүндээ би итгэл төгс байна. Монгол хүмүүс хөдөлмөрч дээр нь өндөр боловсролтой. Тэд улс орноо өсөн дэвжихийг харахыг хүсэж байгаа. Ашигт малтмалын салбар дөнгөж эхлэл үедээ явж байна. Гэсэн ч хаалганы чинь цаана бүтээгдэхүүний хэрэглээгээрээ тэргүүлэгч гүрэн сууж байна. Монгол улс дэлхийн хамгийн баян улсуудын нэг байх ёстой. Тэнд хүрэхэд тийм ч хол биш байх болов уу гэдэгт итгэж бас хүсэж байна.

Лхагвадорж: Монгол улсад чинээлэг үндэстэн болох боломж бүрэн бий. Гэвч танд уул уурхайн салбарт анхаарал хандуулахаас гадна эрүүл, боловсролтой хүмүүст байнгын анхаарал тавьж ажиллах хангалттай тэвчээр байх нь зүйтэй. Учир нь тэдгээр хүмүүс улс орны хамгийн үнэт баялаг байдаг. Улс орны тэргүүлэх зорилго энэ байгаасай гэж хүсэж байна.

Матт: Одоо бол нөгөө л Оюутолгой, Тавантолгойн тухай яриад байдаг. Үүний оронд Оюутолгой, Тавантолгойн дараа бидэнд ямар шинэ боломж, гарцууд байгаа бол гэдгийг харж эхлэх хэрэгтэй. Одоо байгаагаасаа хэр ихийг авч болох талаар бодохын оронд үүний дараа яах вэ, ямар боломж байгаа вэ гэдгийг харж эхлэх нь зүйтэй. Илүү их нөөц боломж байгаа гэдэгт би итгэлтэй байна. ■

ДЭД БҮТЭЦ

ЛОГИСТИК ИНФЛЯЦИЙГ ХАЗААРЛАХ ШИДТЭЙ

Б.УУГАНБАЯР

...Монголын логистикийн холбооноос хийсэн судалгаагаар манай бизнес эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүний үнийн зардлынх нь 30 орчим хувь нь тээвэр, хадгалалт буюу логистикийн буруу шийдлээс хамааралтай байдаг нь үнэ өсөхөд нөлөөлж байна...

Монголд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн зохицуулалт, хяналт байхгүйгээс хүнсний дэлгүүр, супермаркет, захын худалдаачид амандаа багтсан үнээ хэлдэг. Тухайлбал, “Калерина” гээд ургамлын тосны үнийг аваад үзье л дээ. Нийслэлийн “Баянзүрх” худалдааны төвд 2600 төгрөг, МУБИС-ийн дэргэдэх “Макс” худалдааны төвд 2950, “Sky” худалдааны төвд 3100 төгрөгөөр худалдааж байх /өнгөрсөн сарын 1-ний байдлаар/ жишээтэй. Хоорондоо хэдхэн алхамын цаана байрлах дэлгүүрүүдэд 500 орчим төгрөгийн зөрүүтэй байна гээд бод доо. Түүнчлэн хотоос алслагдах тусам бараа, бүтээгдэхүүний үнэ бараг хоёр дахин нугарч өсдөг тухай судалгаа байна. Монголын логистикийн холбооноос хийсэн судалгаанаас үзэхэд манай бизнес эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүний үнийн зардлынх нь 30 орчим хувь нь тээвэр, хадгалалт буюу логистикийн буруу шийдлээс хамааралтай байдаг нь үнэ өсөхөд нөлөөлж байна. Энэ нь бага орлоготой иргэдийн амьдралыг улам туйлдуулж, хүнд дарамт болж буй юм.

Тэгвэл дэлхийн бусад оронд

ямар ч бараа бүтээгдэхүүний үнэ манайх шиг ийм их ялгаатай байдаггүй. Бараа, бүтээгдэхүүндээ шингээх тээвэр, хадгалалтын зардал нь 15 орчим хувьтай байдаг аж. Ингэхдээ зах зээлийн эдийн засгийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр логистикийн бодлогоор үнийг тогтворжуулдаг юм байна. Үүнийг АНУ, Чех, Герман болон Азийн өндөр хөгжилтэй орнууд бүрэн нэвтрүүлж чаджээ. Тухайлбал, эдгээр улсад логистикийн асуудал хариуцсан тусдаа байгууллага байдаг бөгөөд улсын хэмжээнд нэгдсэн системтэйгээр тээвэрлэлт, түгээлтийг зохицуулдаг байна. Мөн бараа, бүтээгдэхүүний үнийг хэрхэн тогтоохыг нарийн томъёолж, хуулиндаа тусгасан байдаг учир үнэ ил тод, тогтвортой, зах зээлийн харилцаа нь эрүүл явдаг гэдгийг Монголын логистикийн холбооны тэргүүн А.Мөнхболд онцолсон.

Үнийн дарамтаас “салгахад” логистик тусална

Тэгвэл үнэ өсөхөд голлож, нөлөөлөөд буй тээвэр, хадгалалтын

зардлыг бууруулж, логистикийн системийг хөгжүүлэх боломжийг Монголын логистикийн холбоо болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийнхэн хамтран судалж буй юм. Монголын логистикийн холбооны тэргүүн А.Мөнхболд хэлэхдээ “Манай инфляцийн 60 хувь нь зохиомол өсөлт. Иргэдийн нуруун дээр ирж буй инфляцийн дарамтыг бууруулж, үнийг тогтвортой барихын тулд логистикийн бодлогоор дэмжиж, үр дүнд хүрч болно” гэв. Манай улс логистикийн бодлогыг өндөр түвшинд хөгжүүлж чадсан Герман улсын бэлээхэн туршлагаас суралцаж болох юм. Логистикийг хөгжүүлэхийн тулд нэн тэргүүнд хийх ажлыг ч дээрх байгууллагынхан жагсаажээ. Тухайлбал, нийслэлд тав, аймаг тус бүрт нэг Логистикийн төв байгуулж, түүгээрээ дамжуулан улсын хэмжээнд ачаа бараа эргэлтийг нэг системд оруулан, зангидах боломжтой. Дээр нь Логистикийн төвүүдийн үйл ажиллагааг холбож, мэдээлэл өгч байдаг Ачаа тээврийн нэгдсэн зуучийн албыг бий болгох боломжтой. Ингэснээр бараа, эргэлтийн оновчтой зөв сүлжээг бүрдүүлэн үргүй зардлаа багасгаж, өгөөжөө дээшлүүлж, үнийг тогтворжуулж болох юм иргэдийн нуруун дахь үнийн дарамт буурах юм байна. Монголын компаниуд дор бүрнээ бараа, бүтээгдэхүүн түгээдэг тээврийн хэрэгсэл, борлуултын сувагтай нь олзуурхах зүйл биш бололтой. Учир нь байгууллагууд энэ бүх зардлаа бараа, бүтээгдэхүүндээ ▶



► шингээдэг учир нэгж бараанд ногдох тээвэр, хадгалалтын зардлын хэмжээ өсдөг. Нөгөөтэйгүүр компаниудын хувьд ч зарлагатай. Учир нь, бараа түгээлтээ хийхдээ нэг талдаа хоосон явж, цаг хугацаа, шатахуун тосоо дэмий үрж, үргүй зардал их гаргадгийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /ГОУХАН/-ийн захиргааны ажилтан Н.Батзориг онцолсон. Хэрэв компаниуд тээвэр, логистикийн системээ оновчтой болговол өөрсдийн олох ашиг нь улам л нэмэгдэнэ гэсэн үг. Түүнчлэн компаниуд бараа, түгээлтээ хийхдээ ажлын ид ачааллын үеэр буюу 11.00-13.00 цагийн үед биш оройн цагаар түгээдэг хэлбэрт шилжвэл бензин тос, цаг хугацааны хувьд ч хэмнэлт гарна гэдгийг сануулсан.

Үйлдвэрийн үнийн шошго нааж, агуулахтай больё

Талх, сүү гэх мэт бидний өдөр тутмын хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн төдийгүй барилгын

материал болон бусад төрлийн импортын барааны үнийг бодит түвшинд барих олон арга бий гэдгийг Монголын логистикийн холбооны судлаачид хэлсэн. Тухайлбал, өргөн хэрэглээний болон хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг барих энгийн аргын нэг нь импортын бүтээгдэхүүнд хилийн үнийн, дотоодын бүтээгдэхүүнд үйлдвэрийн үнийн шошго наах. Жишээ нь, урд хилээр нэг кг будаа 1800 төгрөгөөр орж ирсэн гээд биччихвэл дамлан худалдаалагчид үнээ хэт хөөрөгдөж, ашиг олох ямар ч боломжгүй болох аж. Энэ нь иргэдэд мэдээлэл нээлттэй болж, нөгөө талаасаа компаниудын хувьд зах зээлийн өрсөлдөөн шударга явагдах боломжийг олгох аж. Тус ажлыг эхний ээлжинд нийслэл хотын хэмжээнд туршихаар Монголын логистикийн холбооны удирдлагууд НЗДТГ-ынхантай ярилцаж буй аж. Үйлдвэрийн болон импортын үнийг наах ажлыг энэ ондоо багтаан ажил хэрэг болгохоор зорьж буй юм. Мөн Монголын логистикийн

холбооны зүгээс жижиглэн худалдаа, үйлчилгээний салбарт одоо мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд бараа бүр дээр худалдаалах үнэ, хугацааг заавал бичүүлэх зааврыг хүргэж буй юм байна. Түүнчлэн үнийн хөөрөгдөлд хамгийн их өртдөг бараа, бүтээгдэхүүн төдийгүй өргөн хэрэглээний барааг хадгалах улсын хэмжээний томоохон төрөлжсөн агуулахыг барих нь үнэ өсөхөөс сэргийлэх нэг арга аж. Ингэхдээ, Мөнхболдын санал болгож буйгаар өндөр хөгжилтэй орны жишгээр нийслэлдээ хүнсний болон бусад бараа, бүтээгдэхүүний төвлөрсөн агуулахыг Хотын захиргааны зүгээс бий болгох хэрэгтэй. Учир нь манайд одоогоор агуулахын стандарт алдагдсан, хүртээмж муу байдаг нь худалдаачдад үнээ өсгөх далим болдог байна. Дээр нь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын асуудал орхигдсоор. Тиймээс манай улс баруун, зүүн, төвийн бүсийг түшиглэн чанар, стандартын шаардлага хангасан томоохон ►

дөрвөн агуулахыг энэ тэргүүнд барих шаардлагатай аж. Өндөр хөгжилтэй орнуудад олон нийтийн агуулах гэж байдаг бөгөөд энд бусад агуулахаас 50-60 хувиар үнээ доогуур тогтоодог байх жишигтэй. Тэгэхээр бараа бүтээгдэхүүний тогтвортой, найдвартай нийлүүлэлтийн систем үүсч, үнэ хэт хөөрөгдөхөөс сэргийлдэг байна. Үүнээс гадна манай улсын шүдний өвчин болсон шатахууны тал дээр 100 мянган тоннын агуулах барьж, тухайн жилийнхээ үнийг тодорхой хэмжээнд барих боломж бий аж. Тэгэхээр “Саалиа бэлдэхээр саваа бэлдэх” ажилд ханцуй шамлан орох хэрэгтэй байна.

Сайн эхлэл барилгын салбараас

Хаврын улиралд импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ өсдөг буруу хэвшлийг халж, барилгын материалын үнийг тодорхой хэмжээнд барих ид шид логистикийн бодлогод бий аж. Монголд барилгын салбарын

500 үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж буй ч үйлдвэрлэлдээ ашиглаж буй материалын 60 хувийг импортоор авч буйг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга илтгэлдээ дурджээ. Ингэхлээр, импортын үнэтэй барилгын материал хэрэглэж буйгаас орон сууцны үнэ өсөхөд нөлөөлж буйг мэргэжилтнүүд хэлдэг. Тухайлбал, бид барилгын гол нэр төрлийн материал болох ган, цемент, арматур, сантехникийн хэрэгслүүд, цонх, хаалга, будгаа импортоор авдаг. Тэгвэл нийслэлээс 200 км зайд буюу Чойр хотод жилдээ 17 сая тонн ачаа эргэх хүчин чадалтай барилгын агуулах барих саналыг Монголын Логистикийн холбооноос боловсруулжээ. 79 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар босох тус агуулахыг барилгын томоохон компаниуд өөрсдийн хөрөнгөөр барих юм байна. Харин төрийн зүгээс таван тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төмөр зам барихад шаардлагатай байгаа аж. Тус агуулахыг ашиглалтад оруулсанаар компаниуд импортын

барилгын материалаа нөөцөлж, хавар барилгын ажил эхлэхэд материалар хомсдож, гачигдах зовлонд унахгүй. Үнэ ч тогтвортой байх боломжтой гэдгийг Монголын логистикийн холбооны судлаачид сануулж байна.

Эцэст нь дурдахад, чөлөөт зах зээлийн нийгэмд шилжээд 20 гаруй жилийг үдэж буй Монгол улсад 490 гаруйхууль мөрдөгдөж буй ч логистикийн тухай нэг ч үг, өгүүлбэр, зүйл заалт тусгаагүй байгаа нь өрөвдөлтэй хэрэг. Энэ чиглэлээр салбарын яам, агентлаг болон боловсон хүчнийг бэлдэх талаар ч тухайлсан бодлого алга. Дээр нь Үнийн тухай хууль, логистикийн нэгдсэн бодлого байхгүйгээс худалдаачдын аманд багтсан үнээр иргэд бараа, бүтээгдэхүүнээ авч, үнийн дарамтад орж, амьдрал нь туйлдсаар байна. Үүнийг зохицуулах гарцыг хайж буй Монголын логистикийн холбоо, ГОУХАН-ийн санал, санаачлагыг дэмжиж, логистикийн дорвитой бодлого явуулахад ур, ухаанаа уралдуулах “хоншоортой” байхыг улс төрчдөд уриалъя. ■

KHATAN TUUL
Pure Water

Packaging quantity of Pure water:
0.35 L /bottled/
0.6 L /bottled/
1 L /bottled/
19 L /ballon/

Маркетинг: 99071655
Захиалга авах утас: 70173386
Факс: 976-11-70174494

Produced and bottled by "Welmon Trade" Co., Ltd of Mongolia

ЗОЧИН

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ЦААНА

...Засгийн газар Парламент байдгийн нэг учир нь хоорондоо сонголт дээр мэтгэлцэж болдогт оршдог. Хэрэв нийгмийн нэн ядуу хэсгийг үнэхээр чиглэж чадсан бол хүүхдийн тэтгэмж бол нүдээ олсон зарцуулалт. Харин дундаж давхаргынхны хувьд энэ мөнгө тийм ч нэмэр болдоггүй...



Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийн Дэд ерөнхийлөгч Памела Кокс манай улсад есдүгээр сарын 19-22-нд анх удаа айлчиллаа. Тэрбээр 30 гаруй жилийн ажлын туршлагатай бөгөөд Зүүн Азийг хариуцахаасаа өмнө Дэлхийн банкны Латин Америк, Карибын бүсийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. Хөгжлийн асуудлаар мэргэжсэн аж.

Кокс айлчлалынхаа үеэр Засгийн газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, Монголын хөгжлийг цаашид хэрхэн дэмжиж, эмзэг давхаргын амьжиргааг сайжруулахад Дэлхийн банкны зүгээс үзүүлж буй туслалцаа дэмжлэгийн талаар санал солилцсон билээ. Түүнчлэн хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөл болон хэвлэл мэдээллийнхэнтэй ч уулзаад амжсан юм.

-Монголд анх ирж байгаагийн хувьд төрсөн сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?

-Ирээд ойролцоогоор 12 цаг болж байгаа ч Дэлхийн банк, Олон улсын санхүүжилтийн корпораци болон хувийн салбарынхны санхүүжүүлж буй төслүүдтэй танилцлаа. Тухайлбал, бид өөрсдийн дэмжиж

ажиллаж байгаа хөдөө, орон нутгийн иргэдийг цахилгаанаар хангах нарны эрчим хүчний хэрэгжилтийг болон салхин цахилгаан станцыг /“Ньюком” компани барьж буй/ харлаа. Төсөл хөтөлбөрүүдийн маань зорилго нь тогтвортой амжиргааг дэмжихэд чиглэдэг. Тэдгээрээр дамжуулан нийгмийн хэсэг бүлгүүд биеэ даан цааш хөгжих суурь тавигдаж, шийдвэр гаргах түвшинд хүрч байх нь бидэнд чухал. Бид замыг нь зааж өгөх төдий л үүрэг гүйцэтгэдэг гэх үү дээ.

-Монголд анх ирж байгаа хүний хувьд эдийн засгийн огцом өсөлт болоод түүний үр нөлөө танд хэрхэн ажиглагдаж байна вэ?

-Дэлхийн банк хүртэл Монгол улсын уул уурхайн тэсрэлтэд гар бие оролцож байгаа. Олон улсын санхүүжилтийн корпораци Оюутолгойд хөрөнгө оруулж байгаа бол хөрөнгө оруулалтыг баталгаажуулж, гар барьдаг “Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг” хөрөнгө оруулалтуудад баталгаа гаргахаар мөн ажиллаж байна. Надад юу сонирхолтой санагдсан бэ гэхээр Монгол улсад байгалийн баялгаас гадна бусад гайхалтай боломж байдаг нь харагдлаа. Бид салхин станцын талаар түрүүхэн ярьж байлаа. Монголын хувьд маш их нар, салхины

нөөц байна. Энэ нь тэдгээр баялгаас гарган авсан эрчим хүчээ экспортлох боломж бий гэсэн үг.

-Сэргээгдэх эрчим хүчийг экспортлох нь урт хугацаанд эдийн засгийн ач холбогдолтой стратеги байх боломжтой юу?

-“Ньюком” компанийн хийж буй ажлаас харахад, байна. Гэвч Монгол орны хувьд онцлог давуу тал бий. Байгалийн баялаг ихтэй уудам газар нутаг бүхий энэ орон нэг тэрбум гаруй хүн амтай аварга эдийн засагтай хоёр орны дунд байрладаг. Энэ бол итгэмээргүй том боломж. Үүний зэрэгцээ танайх Япон, Солонгос улсын эдийн засагтай дээрхээс дутахгүй ойрхон. Азийн олон орны эдийн засаг өндөр өсөлттэй яваа. Тиймээс Монгол улсыг гайхалтай сайхан газар зүйн байршилтай орон гэж хэлнэ.

-Дэлхийн банкны бусад бүс нутгийн удирдах албан тушаалд ажиллаж байсан хүний хувьд өнөөдөр ажиллаж буй Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн онцлогийг дурдахгүй юу?

-Юун түрүүнд Зүүн Ази нь удаан хугацаанд тогтвортой өссөөр өдийг хүрсэн бүс нутаг гэдгийг онцолмоор байна. Мөн тус бүс нутаг ядуурлыг бууруулах, хүн амынхаа боловсролын



► түвшинг ахиулах тал дээр жинтэй ахиц дэвшлийг харуулсаар ирсэнийг ч хэлэх хэрэгтэй болов уу. Эдийн засгийн утгаараа Зүүн Ази нь тасралтгүй хөдөлгөөнд оршиж байна. Өнөөдөр дэлхийн бусад бүс нутаг Зүүн Азийг анхааралтай харж сууна.

-Хөгжиж буй эдийн засагтай орнуудтай харьцуулахад Монгол улсын байр суурь хаана явна вэ?

-Энэ бүс нутгийн нэг хэсэг болохын хувьд Монгол улсад аливаа зүйлийг зохих ёсоор нь хийх боломж бүрэн байна. Ашигт малтмалаа удирдан чиглүүлэх тал дээр өнөөдрийг хүртэл олон улс орон юу нь зөв, юу нь буруу болохыг ялгаж салгах хэмжээнд чамгүй хичээл заалгалаа. Недерланд улс байгалийн баялгаа зөв захиран зарцуулж чадаагүйгээс үүдэн бий болсон Голланд өвчин тэргүүтэй олон гашуун туршлагыг зарим нь биеэрээ

амссан. Тиймээс Монгол улс бусдын жишээнээс сургамж авч, дэлхийн улс орнуудын бүтээлч туршлагаас хуваалцах сайхан боломжийг ашиглана гэдэгт итгэж байна.

-Та яг ямар боломжуудын талаар ярьж буйгаа тодруулахгүй юу?

Монголд жижиг, том олон боломж байна. Бидний хувьд томоохон төслүүдэд хөрөнгө оруулахын зэрэгцээ амьдралын боломж тааруу хүмүүст зориулсан төслүүдэд ч хөрөнгө оруулалт хийдэг. Энэ нь бид зөвхөн зоосны нэг талд анхаардаггүй гэсэн үг юм.

Монгол компанийн удирдлаган дор үйл ажиллагаа нь урагшилж буй салхин станцын явцтай бид танилцлаа. Энэ нь Монгол улсын хувьд эрчим хүчний тогтвортой эх үүсвэртэй болох нэг алхам юм. Үүний зэрэгцээ бид нарны эрчим

хүчээр хэрэглээгээ шийдэх нарны дэлгэцийг малчдад олгох төсөлтэй мөн танилцсан. Хөдөө талын малчин өрх шөнө оройн цагаар ном сонин уншиж, телевиз үзэж суух тогтой байна гэдэг гайхалтай боломж шүү дээ. Энэ бол бидний том, жижиг гэж ялгалгүйгээр нийгмийн хэсэг бүлгүүдэд гар сунгаж чаддагийг харуулж буй жишээ юм.

-Манай улсын голлох хэрэгцээг Та чухам юу гэж харж байна вэ?

Боловсролын салбар дахь асуудлыг анхаарч эхэлсэнд би их баяртай байгаа. Учир нь энэ оронд асар их боломж байгаа боловч хүн ам нь гуравхан сая юм. Улс орны хувьд ирээдүйд амин чухал хэрэгцээ болох нь тодорхой байгаа боловсрол, хүний нөөц хоёрыг нэгтгэж мэдлэг чадвар болгоно гэдэг хүндхэн сорилтуудын нэг байх ►



Фотог Э.Зоригт

► нь гарцаагүй. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр эдийн засгаа төрөлжүүлж боловсролын боломжийг бий болгох хэрэгтэй. Ганцхан ашигт малтмалын салбарт найдаж болохгүй. Хүмүүст ажлын байрны сонголт байх ёстой. Боловсрол бол түлхүүр.

-Хятадын эдийн засгийн удаашрал, нүүрсний үнийн уналтаас үүдэн манай улсын төсөвт асуудал гараад эхэлчихлээ. Монгол ямар сонголтыг хийж болох вэ?

Хийж хэрэгжүүлэх ажлаа богино хугацааны болон урт хугацааны гэж ангилж болох юм. Зарим нэг төслүүдийг хойшлуулах, эн тэргүүний бус зорилгуудыг хоёрт тавьж нэн шаардлагатай зүйлст мөнгө зарцуулах гэх мэтээр хяналт тавих нь зүйтэй. Улс орнуудын туршлагаас харж байхад дунд хугацаанд ашигт малтмалын экспортоос хэт

хамааралтай улсууд байгалийн баялгаас олж буй орлогын хүлээснээс суллагдах арга замаа тодорхойлох хэрэгтэй байдаг. Жишээ нь, Чили улсыг харж болно. Бид тус улсыг Монголтой холбож өгсөн учраас арвин туршлагаас нь суралцах боломжтой. Чили улс зэсийн экспортоос ихээхэн хамааралтай орон гэдэг нь үнэн. Гэвч тус улс Тогтворжуулалтын сантай бөгөөд зэсийн үнэ өндөр үед тус санд хөрөнгөө хуримтлуулдаг. Харин зэсийн үнэ уруудахад төсвийн зарлагаа хянаж хэвийн хэмжээнд нь барихад уг хуримтлуулсан орлогоо ашигладаг. Иймээс тус улсад ашигт малтмалын орлогоос хамаарсан төсвийн тогтворгүй байдал үүсдэггүй. Таваарын үнэ хэлбэлздэг нь тодорхойгоос хойш Монгол улсын хувьд ч үүнээс сэргийлэх тохирсон арга зам байж л таарна. Монгол улсад Төсвийн тогтвортой байдлын тухай хууль байдгийг мэднэ. Гэхдээ хамгийн чухал нь төсвийн зарцуулалтыг алдагдуулалгүй асуудлыг шийдэх гарц байх явдал юм. Тиймээс л цаг сайхан үед бүх мөнгөө үрчихэлгүй, нэг хэсгийг нь цааш нь хийж байх хэрэгтэй байдаг.

-Монголд цааш нь хийсэн мөнгө харьцангуй бага байна л даа. Ийм нөхцөлд манайд ямар боломж байж болох вэ?

Ийм нөхцөлд Засгийн газар хэд хэдэн зүйлийг хийж болдог. Нэгдүгээрт, зарим төслийг хойшлуулах. Хоёрдугаарт, төсвийн зарцуулалтаа эргэн харах тэр дундаа нийгмийн халамжид зориулан гаргаж буй мөнгө нүдээ олсон зарцуулалт мөн үү, үгүй юу гэдгийг нягтлах хэрэгтэй юм. Хүн бүрийг бус нийгэмд нэн ядуу гэж нэрлэгддэг хэсгийг л халамжлах нь зүйтэй.

-Манайх өнөөдөр шинээр бүрэлдсэн УИХ, Засгийн газраа эмхэлж цэгцлээд завгүй байна. Бэлэн мөнгө хавтгайруулан олгох байдал өмнөхөөсөө нэг их өөрчлөгдөхгүй дүр зураг ажиглагдаж байгаа л даа. Хэрвээ ингэсэн тохиолдолд эдийн засагт ямар нөлөө үзүүлэх вэ?

Засгийн газар Парламенттай байдгийн нэг учир нь хоорондоо сонголт дээр мэтгэлцэж болдог оршдог. Хэрэв нийгмийн нэн ядуу хэсгийг үнэхээр чиглэж чадсан

бол хүүхдийн тэтгэмж бол нүдээ олсон зарцуулалт. Харин дундаж давхаргынхны хувьд энэ мөнгө тийм ч их хэрэг болдоггүй. Монгол улсын хувьд эрүүл Засгийн газартай юм байна гэж ойлгож байгаа. Сонгууль саяхан болсон ч энэ бүх асуудал руу шуудраад орох Парламенттай гэдгийг харж байна.

-Бусад томоохон зах зээлд хүрэхэд хуурай газраар хүрээлэгдсэн далайд гарцгүй Монголд давах даваа олон бий. Хоёр их гүрэнтэй хөршилсэн худалдааны сорилтуудыг давах ямар боломж бидэнд байна вэ?

Хоёр их гүрэн гэдэг нөгөө талаас бараа таваарыг худалдаж авах аварга том зах зээл гэсэн үг. Монголын экспортын бүтээгдэхүүний 90 гаруй хувь Хятад руу гардаг гэдгийг би ойлгож байна. Гэхдээ энэ бол нөгөө талаас давуу байдал. Далайд гарцгүй орнуудад олон сонголт байж болно. Түүний нэг нь нэмүү өртөг шингэсэн өндөр үнэтэй бараа таваарыг экспортлох явдал юм. Монгол хараахан тэр хэмжээнд очоогүй байж мэдэх ч энэ бол далайд гарцгүй орны сонгож болох арга замуудын зөвхөн нэг нь. Жишээлбэл, эрчим хүч экспортлох бас нэг боломж байна. Нар, салхинаас эрчим хүч гаргаж аваад эхэлбэл дамжуулах шугамаар гадагшаа гаргаж болно. Далайд гарцтай байсан байгаагүй угаас дамжуулах шугамыг хэрэглэх л болно.

-Нөхцөл байдал таагүй байгаа энэ үед Дэлхийн банк санхүүгийн ямар тусламж улс орнуудад үзүүлж чадах вэ?

-Бид өнгөрсөн хямралын үед Монгол улсад тусалсан. Хямралын үед бидний хийж чадах хэд, хэдэн зүйл байгаа. Бид Засгийн газруудад төсвийн тогтвортой байд-лаа хадгалахад тусалж нэмэлт санхүүжилт өгөх боломжтой. Гэвч бидний зүгээс нийгмийн эмзэг давхаргыг дэмжихэд зориулсан хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх мөн иргэдийн хэсэг бүлгээрээ санаачилсан жижиг хэмжээний төслүүдийг санхүүжүүлэхэд голлон анхаардаг.

-Богинохон айлчлалынхаа үеэр манай сэтгүүлд цаг зав гаргасан танд баярлалаа. ■

ҮЛ ХӨДЛӨХ




Н.Монсор /UMC Alpha компанийн гүйцэтгэх захирал/

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ХАНДЛАГА

Бидний үзэж байгаагаар Монголын барилгын сектор 2008-2010 оны хямралыг харьцангуй амжилттай даван туулсан гэж хэлж байна. 2008 он хүртэл орон сууцны үнэ тогтмол 15-20 хувийн өсөлттэй байсан. Харин 2008-2010 онд банкны салбарт үүссэн хямрал барилгад нөлөөлж, барилгын эрэлт, нийлүүлэлтийн санхүүжилт хумигдан эдийн засаг бүхэлдээ хямралын байдалд орсон. Энэ үед орон сууцны үнэ ялимгүй буурсан боловч 2010 оны дунд үеэс эхлэн эргээд өсөж эхэлсэн ба энэ оны есдүгээр сарын байдлаар үнийн өсөлт хамгийн өндөр түвшиндээ хүрээд байна.

Үнийн өсөлтийг Орон сууцны үнийн индекс/ОСҮИ*/-ээс харахад, Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэгт орон сууцны үнэ өмнөх оны мөн үеийнхээс 31 хувь, 2011 оны дөрөвдүгээр улирлынхаас 3,6 хувиар өссөн байна. Үндэсний статистикийн хорооноос улиралд нэг удаа тооцдог.

Орон сууцны үнийн индекс (ОСҮИ) хувиар



Эх сурвалж: ҮСХороо

Орон сууцны үнийн өсөлт хуучин шинэ ялгаагүй өмнөх оны мөн үеэс дунджаар 24-38 хувиар өссөн

үзүүлэлттэй байна. Харин хуучин, шинэ орон сууцны үнийн зөрүү нэлээд гарах болсон. Тухайлбал, хотын төвийн дүүрэгт байгаа хуучин гурван өрөө орон сууцны одоогийн ханш дунджаар 105 сая төгрөг байхад шинэ гурван өрөө орон сууцны (дундаж талбай нь 75 ам.метр) үнэ дунджаар 135 сая төгрөг буюу үнийн зөрүү 30 сая төгрөг болсон байна. Энэ зөрүү цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Шинэ орон сууц

Шинээр ашиглалтад орж байгаа орон сууц болон өмнөх оны мөн үед ашиглалтад орсон орон сууцны үнийг харьцуулав.

Ам метрийн үнэ /мянган төгрөгөөр/

Дүүрэг	Тансаг	Дундаж	Энгийн
ХУД	2,000	1,650	1,300
	3,200	2,200	1,500
ЧД	2,200	1,500	1,200
	2,600	1,900	1,600
БЗД	1,850	1,400	1,100
	2,200	1,700	1,450
БГД	1,400	1,300	1,250
	1,700	1,600	1,450
СХД	1,400	1,200	1,350
	1,800	1,200	1,000
СБД	2,300	1,350	1,100
	2,800	1,700	1,400

Эх сурвалж: UMC Alpha

Хүснэгтээс харахад шинээр ашиглалтад орж байгаа орон сууцны ам метрийн үнэ зэрэглэлээсээ хамаарч 1,4-3,2 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21-30 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Шинэ орон сууцны хувьд зэрэглэл чухал бөгөөд энэ нь үнийг тодорхойлж байгаа гол хүчин зүйл юм. Зэрэглэл

тогтооход нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь:

- Байршил;
- Гадна орчин, тохижилт
- Агаарын бохирдол;
- Барилгын чанар;
- Гүйцэтгэгч компанийн нэр хүнд;
- Хөршүүд;
- Аюулгүй байдал, харуул хамгаалалт;

Хуучин орон сууц

Зарын дагуу борлуулагдаж байгаа хуучин орон сууцны түүвэр судалгаа.

Өрөөний тоо /сая төгрөгөөр/

Дүүрэг	1 өрөө	2 өрөө	3 өрөө
БГД	56.8	77.9	102.0
СХД	46.7	59.5	74.9
БЗД	50.5	74.4	102.4
ХУД	60.0	92.8	92.3
ЧД	55.3	94.3	120.0
СБД	61.0	87.0	103.7
Дундаж	55.1	81.0	99.2

Эх сурвалж: Зар мэдээ, Шуурхай зар

1970 оноос өмнө ашиглалтад орсон орон сууцны үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад зургаан дүүрэгт дунджаар 33 хувийн өсөлттэй, 1970-2001 онд ашиглалтад орсон орон сууц 31 хувийн өсөлттэй, 2001 оноос хойших нь 25 хувийн өсөлттэй байна. Үүнд үндсэн гурван хүчин зүйл нөлөөлж байна.

• Хотын төвийн дүүргүүдэд орон сууцжуулах боломжтой газрын хүрэлцээ хомсдож 1970-аад оноос өмнө ашиглалтад орсон зарим хуучин барилгуудыг буулган дахин барилгажуулж байгаа;

• Шинээр барилгын чанар, стандарт хангасан байдал ерөнхийдөө тааруу; ▶

• Орон сууц барихад шаардагдах дэд бүтцийн хүрэлцээ хангалтгүй, төвийн бүсдээ хэт төвлөрсөн байгаа байдал;

Тэгэхээр орон сууцны үнэ нэмэгдсээр байгаа нь илт. Нэгдүгээрт, үнийг тухайн орон сууцыг барих өртөгтэй харьцуулах байдлаар Хоёрдугаарт, иргэдийн худалдан авах чадварт тулгуурлан Гуравдугаарт, бусад орны орон сууцны үнэтэй харьцуулах байдлаар тодорхойлж болдог.

Үнэ-Өртөг



Эх сурвалж : UMC Alpha

Барилгын үнэ, өртөгийн бүтэц аль ч улсын хувьд дээрх байдлаар задардаг бөгөөд барилгын үнэ өндөр байх нь тэдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлийн хандлагаас шалтгаалдаг.

Барилгын үнийн бүтэц

	АНУ	Монгол
Газар	20.3%	27.1%
Барилга, угсралт	58.9%	52.5%
Санхүүжилтын зардал	1.7%	2.1%
Үйл ажиллагааны зардал	5.4%	5.0%
Маркетингийн зардал	4.8%	2.1%
Ашиг	8.9%	11.2%

Эх сурвалж : NAIH 2009, UMC Alpha

Дээрх хүснэгтээс харахад барилгын нийт өртгийн 60 орчим хувийг барилга угсралт, материалын зардал эзэлдэг.

Манай улсын хувьд барилгын материалаа бараг 100 хувь импортоор авдаг бөгөөд энэ явцад олон нэмэгдэл

зардал үндсэн өртөг дээр нэмэгддэг. Тухайлбал, барилгын материалын хувьд валютын ханш, гаалийн татвар, шатахуун, тээврийн зардал нөлөөлж байдаг бол үйл ажиллагааны зардлын хувьд ажилчдын цалингийн өсөлт, инфляци, зээлийн хүү зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлдөг. Барилгын материалын өртөг дээрх байдлаар олон хүчин зүйлээс хамааралтай байдаг нь зах зээлийн аливаа өөрчлөлтөд илүү мэдрэг гэсэн үг юм. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг тогтолцооных нь хувьд зохицуулалт хийх боломж хязгаарлагдмал байгаа нь барилгын өртөг ойрын хугацаанд буурах боломжгүйг харуулж байна. Иймээс цаашид барилгын өртөг нэмэгдсээр байх дүр зураг харагдаж байна.

Үнэ-Орлого

Орон сууцны үнэ нь нэг хүний жилийн дундаж орлогыг 4-5 дахин өсгөсөнтэй тэнцүү байвал ер нь боломжийн гэж үздэг. Доорх хүснэгтээс энэ үзүүлэлт бусад улсуудын хувьд ямар байгааг харж болно.

Үнийн түвшин	Үнэ/ Орлого	Улс	Хот
Хэт үнэтэй	35	Хятад	Бээжин
	20	ОХУ	Москва
	18	Сингапур	-
Үнэтэй	14	АНУ	Нью-Йорк
	12	Монгол*	Улаанбаатар
Боломжийн	7	Итал	Ром
	6	Австрали	Сидней
Хямд	3	АНУ	Бүхэлдээ

*сарын дундаж цалинг 341 мянган төгрөгөөр тооцов. Эх сурвалж : www.economist.com

Манай улсын хувьд сарын дундаж цалинг 486 мянган төгрөгөөр, дундаж зэрэглэлийн хоёр өрөө байрны үнийг 70 сая төгрөг гэж үзвэл дээрх харьцаа 12 гарч байна. Энэ нь уг ангиллаар “үнэтэй”-д орж байгаа ч энд өрхийн бодит орлогыг хамгийн багаар авч тооцсон. Учир нь манай улсын хувьд иргэдийн бодит орлогыг тооцоход хүндрэлтэй бөгөөд ихэнх төлбөр тооцоо бэлнээр буюу гараас гарт хийгддэг. Үүнийг хянах боломжгүй учраас бодит орлогыг тодорхойлоход хүндрэлтэй юм.


Ойрын ирээдүйд манай улсын эдийн засаг, тэр дундаа уул уурхайн салбарт гарч байгаа эерэг бүтээн байгуулалтууд хүн амын орлогын түвшинг 4-10 дахин нэмэгдүүлнэ гэсэн тооцоог судлаачид гаргасан байдаг бөгөөд үүнтэй уялдан орон сууцны үнэ ч мөн цаашид өсөх хандлагатай байх ерөнхий зураглал харагдаж байна.

Үнийн харьцуулалт

Доорх хүснэгтээс харахад Монголын орон сууцны үнэ хямд байгааг харж болох бөгөөд Азийн орнууд дундаа хамгийн доогуур жагсаж байна. Тэгэхээр цаашид орон сууцны үнэ эрэлтээ дагаад өсөх магадлалтай гэсэн үг.

Манай улсын хувьд орон сууцны эрэлтийг хязгаарлаж байгаа нэг гол хүчин зүйл нь моргейжийн санхүүжилтийн асуудал бөгөөд одоогийн банкны систем үүнийг даах чадамжгүй байна. Одоогоор банкны системд 34 мянган зээлдэгчид 767 тэрбум төгрөгийн моргейжийн зээл олгогдоод байна. Энэ нь системийн нийт зээлийн 10 орчим хувийг эзэлдэг бөгөөд зээлийн чанар хамгийн сайн байдаг. Энэ дүн цаашид өсөх нь Засгийн газраас хэрэгжүүлж байгаа иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр, түүний санхүүжилтээс бүрэн хамаарах болоод байна. Урт хугацаанд манайх бодлогын түвшинд эрэлт мөн нийлүүлэлтийг хоёр талаас нь дэмжсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байж орон сууцны үнийг тодорхой түвшинд тогтвортой барих боломжтой болно. ■

Орон сууцны ам метрийн үнийн харьцуулалт /мян ам.доллараар/



Эх сурвалж: UMC Alpha

ОЮУТОЛГОЙН БУЛАН

БИДЭНД ОЙРХОН ИРЭЭДҮЙ

Б.АЛТАЙ

...“Оюутолгой бол дэлхийд олдсон хамгийн чанарлаг алт, зэсийн орд” хэмээн гаднынхан үнэлдэг...

“Монголын эдийн засагт уул уурхайн салбар тэргүүлэх байр сууриа ойрын 30 жилд хадгална. Учир нь өнөөдөр Монголд уул уурхайтай өрсөлдөх салбар алга. Хүссэн ч, эс хүссэн ч уул уурхайгаар гадаад худалдаагаа тэнцвэржүүлж, эдийн засгаа хөгжүүлж, ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлэх энэ зорилт аль ч Засгийн газарт гарч ирсэн. Тиймээс уул уурхайгаас дайжих, түүнээс зайлах, гажих зам байхгүй” гэж “Discover Mongolia-2012” чуулганы үеэр Монгол улсын анхны Ерөнхийлөгч асан П.Очирбат хэлсэн билээ. Түүнчлэн “Монгол улс уул уурхайн баяжуулах цогцолбороос уул уурхай, металлургийн цогцолборт хамтын хүчээр орвол Зүүн хойд Азийн зах зээл, бүр урагшаа Хятад, Энэтхэг, Японы зах зээлд ч нэвтрэх боломж нээлттэй байна. Тэнд эрэлт байна” хэмээн тэрбээр онцлов. Биднийг ийм боломжит зах зээл хүрээлэх аж. Тэгвэл боломжит зах зээлд бид тоглогч байх нөөц, бололцоо хэр байна вэ.

Монголын эдийн засагт Оюутолгой төслийн гэх хаягтай хөрөнгө оруулалт эргэлдсээр. Үндсэндээ Монгол улсын эдийн засгийн тамир тэнхээ зөвхөн нэг компанийн хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай болж эхэллээ. Эдийн засаг тэлэх найдвар нь



Оюутолгой төсөл. Монгол улс хөгжих, эс хөгжих нь тус ордоос шууд хамаарах аж. Ийм хүлээлт ч нийгэмд бий болов. Тийм сонирхол ч баялгийн эздэд төрөх боллоо. Үүнийг цаг үе, зах зээл зэрэг шаардав. Товчхондоо нэг компанийн бүтээн байгуулалт, татварын орлого нь Төв Азийн Монгол орны өнгө төрхийг өөрчлөхөд ядах юмгүй зүйл болохыг өнгөрсөн хугацаанд үзлээ. Далайцтай хөрөнгө оруулалт зөвхөн уул уурхайн салбарт бус бүхий л нийгмийн салбарт жигд хүрэх гэнэ. Үүний өгөөжийн дүнд Монголын эдийн засагт өнгөрсөн хугацаанд чамлахааргүй амжилт гарсаныг зарим эдийн засагчид онцлон тэмдэглэх болов. Тэгвэл ирэх онуудад эдийн засгийн амжилтаа бататгах цаг үе тулгарч байна.

Арван жилийн түүхэн замналтай “Discover Mongolia-2012” Олон улсын

хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын үеэр “Оюутолгой” төслийн Монголын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг гаднынхан онцолж байв. Тэгвэл өмнийн говьд буй орд газрынхаа өгөөжийг монголчууд түрүүлээд хүртэх боллоо. “Оюутолгой” компани нь Монголын эдийн засагт 2010 онд 96 сая, 2011 онд 375 сая, 2012 оны эхний хагаст 171 сая ам.долларын татвар төлж, зөвхөн энэ оны эхний зургаан сард 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт буюу өдөрт зургаан сая ам.доллар зарцуулаад байгаа гэсэн жинтэй тоог тус чуулганы үеэр олж сонссон юм. Мэдээж монголчууд орд газраасаа ахиу ашиг хүртэхийг эрмэлзэнэ шүү дээ. Оюутолгой төслөөс хамгийн багадаа Монголын 10 салбарт ашиг хүртэнэ гэсэн мэдээлэл бий. Тодруулбал, үйлдвэрлэлийн салбар эрчимжинэ, улсын төсвийн

орлого нэмэгдэнэ, дотоодын нийт бүтээгдэхүүн өснө, шинэ техник, технологи нэвтэрнэ, шинэ ажлын байр нэмэгдэнэ, чадварлаг, дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц боловсон хүчинтэй болно. Мөн эрчим хүчний үйлдвэрлэл өснө, орон нутгийн дэд бүтэц хөгжинө, дотоодын зах зээл дэх бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нэмэгдэнэ, ард түмний амьжиргаа дээшилнэ гэж үзэж байна. Оюутолгой төсөл үйлдвэрлэлийн эхний 10 жилд хүчин чадлаараа жилд дунджаар 1.2 тэрбум фунт (544,000 тонн) зэс, 650,000 унци алт, гурван сая тонн зэс тус тус үйлдвэрлэх аж.

Нэгэн сонирхолтой жишээ дурдахад монголчуудын сүүлийн үед нийтлэг унадаг болсон “Тоёото приус” автомашиныг үйлдвэрлэхэд 50 кг зэс ордог аж. Ердийн машинд бол дунджаар 25 кг зэс ордог байна. Ирээдүйд бүх машин гибрид болно гэдгийг машин үйлдвэрлэгч компанийн эзэд аль хэдийнэ мэдэгдсэн. Тиймээс “Ниссан”, “Тоёота” бүгд л дээрх чиглэлд үйлдвэрлэлээрчимжүүлсээр. Гибрид машин нь байгаль орчинд ээлтэй, бензин бага зарцуулдаг давуу талтай билээ. “Женерал моторс”, “Форд”, “Хонда” энэ төрлийн автомашин хийж, түүнийгээ ч шинэчлэн сайжруулсаар. Товчхондоо, автомашины зах зээл улам л төгс төгөлдөрт ойртох гэж тэмүүлсээр байна. Зөвхөн “Тоёота” гэхэд л нэг жилд үйлдвэрлэх гибрид машиныхаа эд ангид зориулж 700 мянган тонн зэс худалдаж авдаг гэсэн тооцоо бий. Тэгвэл ийм хэмжээний зэсийн хэрэгцээ нь Чилийн хувьд том олз юм. Гэхдээ автомашины үйлдвэрлэлийн зэсийн хэрэглээг дангаар Чили хангана гэвэл гунигтай. Харин Монгол улс Чилээс дутахгүй ханган нийлүүлэгч байх боломжийг Оюутолгой орд олгож байна.

“Оюутолгой бол дэлхийд олдсон хамгийн чанарлаг алт, зэсийн орд” хэмээн гаднынхан үнэлдэг. Тэгвэл Монгол улсын түүхийн нэгэн шинэ үе эхлэх гэж байна. Бидэнд ирээдүйг ойртуулах төслийн бүтээн байгуулалт өмнийн говьд сүндэрлэн босож байна. Дөнгөж л саяхан “Оюутолгой” төслийн

Хөрөнгө оруулалтын гэрээг баталсан гурван жил, түүнийг шүүмжилсэн гурван жил, хамтдаа бүтээн байгуулсан гурван жил он цагийн буулганд дарагдан ард үлдэж байна. Монгол улс хөгжих гэж Азийн “бар” орны зиндаанд хүрэх гэж тэмүүлсээр. Зүтгүүр нь дэлхийн гурав дахь том зэсийн уурхай болох Оюутолгойн орд. Ирэх онд үйл ажиллагаагаа эхлүүлэх гэж буй тус орд Монголын эдийн засагт найман их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг шингээж буй. Түүнчлэн Монголын Засгийн газарт уурхайн орлогын 55-70 хувийн төлбөр, татвар, нөөцийн төлбөр төлөх учиртай.

2020 он гэхэд Оюутолгойн зүгээс төлж буй татвар, ногдол ашиг нь Засгийн газрын орлогын 30 гаруй хувийг эзлэх аж. Үүний дүнд манай эдийн засаг одоогийн 17 хувиас 35 хувь хүртэл өсөх таамгийг гаднын шинжээчид дэвшүүлсэн нь учиртай. Хэдий урд хөршийн эдийн засаг суларч, Евро бүсийн хямрал дэлхий нийтийг ороосон ч эрдэс баялагт итгэж болохоор. Учир нь “Зэсийн үнийн урт хугацааны таамаглал эерэг байгаа” хэмээн “Рио Тинто” компанийн Зэсийн салбарын захирал Эндрю Хардинг ярьжээ. Өнгөрсөн хугацаанд манай улсын эдийн засаг тэлж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт гэрлийн хурдаар өсөв. Иргэдийн цалин орлого, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэхийн хэрээр хөгжлийн галт тэрэг хурдаа нэмсэн билээ. “Оюутолгой”-н ил уурхайгаас өдөрт 100 мянган тонн хүдэр олборлох бөгөөд ирэх 2017 он гэхэд далд уурхай бүрэн ашиглалтад орох юм. Түүнчлэн уурхайн хүдэр боловсруулах хүчин чадлыг өдөрт 160 мянган тонн хүртэл өргөтгөх судалгааны ажлыг эхлүүлэхээр болсон байна. Нэг үгээр хэлбэл зэс, алт, мөнгө, молибдений бүлэг орд тун удахгүй эдийн засгийн эргэлтэд орно. Монголын эдийн засгийн зүтгүүр, хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхлын луужин болсон Оюутолгой орд газарт бүтээн байгуулалт нүргэлсээр. Төслийн эхний үе шат буюу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ирэх онтой зэрэгцэн хөшгөө нээх гэж байна. ■

...Монгол улсын эдийн засгийн тамир тэнхээ зөвхөн нэг компанийн хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай болж эхэллээ. Эдийн засаг тэлэх найдвар нь Оюутолгой төсөл...

АШИГТ МАЛТМАЛ-97

ТӨВ ЕВРОПООС МОНГОЛД

Б.ТОГТОХ

1997 оны Ашигт малтмалын хууль Монголд уул уурхайг, Монголын уул уурхайг дэлхийн тавцанд ойртуулсан гэж тус салбарынхан үздэг.

М.Э.Ө 256 оны үед Эртний Ромд уурхайг үнэ хаялцуулан шалгаруулж, өндөр үнэ хэлсэнд нь ашигт малтмал олборлох эрхийг олгодог байжээ. Өөрөөр хэлбэл, одоогийн нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар анхны тендерийг өрнүүлж, түүнийг дагасан уул уурхайн анхны гэрээ хэлцэл түүхийн шинэ хуудсаа дэлгэсэн байна. Тэгвэл манай эриний хоёрдугаар зуунд Өмнөд Португальд хувь хүмүүст зэс, мөнгөний уурхайг ашиглах эрхийг анх удаа олгож, орон нутагт татвар төлөх журам тогтоосон нь өнөөдөртэй золгожээ. Уул уурхайн насжилт хэдэн мянган жилийн түүхийг өгүүлэх бололтой. Тэртээх М.Э.Ө Ромын гэрээ хэлцэл, эрх зүйн суурь эцэг өвгөдөөс улбаалан ирсэн мэт сэтгэгдэл төрүүлэхээр байна. Уул уурхайн салбарт “алдаршсан” нэгэн үг бий. “Уул уурхайгүйгээр соёл иргэншил оршин тогтнохгүй. Хууль тогтоомжоор түүнийг боомилбол бүх юм үгүй болно” гэж. Тэгвэл уул уурхайг эрх чөлөөтэй эрхлэх үзэл баримтлал XII зууны сүүлчээр Төв Европт албан ёсных болжээ. Эндээс л өнөө цагийн хариуцлагатай уул уурхай түүчээлсэн байна. XVI-XX зууны эхний хагаст Европын ашигт малтмалын эрх зүйн уламжлал дэлхий даяар тархсан нь колончлолын үе болж таарсан гэдэг.

Европоос “хуулсан” уул уурхайн “сурах бичиг” 1950-1970 оны хооронд хэн бүхний мэддэг шинжлэх ухааны салбар болтлоо тэлсэн аж. Дэлхийд түгээмэл Ашигт малтмалын тухай хуулийн хэв загвар өнгөрсөн 1980 он хүртэл Библи мэт тархаж, түүний номлол 90 гаруй орны үндэсний соёл мэт хэв шинжээ олсон байна. Эндээс л Монгол улсын ашигт малтмалын тухай хууль санаа сэдэл авч, 1988 онд Газрын хэвлийн тухай хууль мэндэлжээ. Тус хууль нь одоогийн Ашигт малтмалын тухай хуулийн хөрс нь болсон гэдэг. Түүхийг сэргээн өгүүлэхэд 1997 оны Ашигт малтмалын хууль Монголд уул уурхайг, Монголын уул уурхайг дэлхийн тавцанд ойртуулсан гэж тус салбарынхан үздэг. Хэдий уг хуулийг батлаад 15 жил өнгөрсөн ч М.Энхсайханы Засгийн газрын үеийн туг болсон бүтээлийг олонх онцолж, цөөнх нь шүүмжилдэг. Арван таван жилийн өмнө Монголын уул уурхайн салбарт нэрээ мөнхөлсөн Ашигт малтмалын тухай хуулийг одоогийн УИХ-ын гишүүд шүүн хэлэлцэх, шүүрч аваад гараа өргөх бус нэлээн нухацтай хандах шинэ хуулийн төсөл болон өнгө зүс, мөн чанараа өөрчилсөн сурагтай. Шинэ хуулийн төсөл энэ намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад дээгүүр яваа.

1.

“Ашигт малтмалын анхны хууль 1994 онд батлагдсан. Улмаар 1997 онд шинэчлэгдсэн. Дахиад 2006 онд шинэчлэгдсэн. Үүний завсараар янз бүрийн хууль гарав. Цөмийн энергийн тухай хууль, “Урт нэртэй” хууль, 68 хувийн татвартай холбоотой хуулиуд

байна. Хамгийн гол нь эдгээр хуулийг судалгаагүй, бодлогогүй гаргадаг. Ерөөсөө л уул уурхайгаас ахиу мөнгө авна гэсэн хандлага улстөрчдөд давамгайлсантай холбоотой. Жишээ нь 68 хувийн татварыг авч эхэлснээс болж манай ихэнх алтны компаниуд дампуурсан. Үүний цаана байгаль орчин, аюулгүй байдлаа үндсэндээ хаясан. Сүүлд хуулийг олон нийтийн байгууллага, үйлдвэрүүдийн шахалтаар хүчингүй болгосон. Гэтэл нөгөө хуулийн оронд ахиад нэг хууль гараад ирэх жишээтэй” хэмээн Монголын ашигт малтмал баяжуулагчдын холбооны ерөнхийлөгч Г.Шархүү уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчинг ингэж дүгнэсэн юм. Тэрбээр “Хууль бол ерөнхий бодлогын юмыг сайн зохицуулсан байх ёстой. Тэр 68, 34, 66 зэрэг тоог Засгийн газрын тогтоолоор тооцоо үндэслэлтэй гаргахгүй бол ийм хуулиудаас болж улс орны хөгжил, гадаадын хөрөнгө оруулалтад муу нөлөө үзүүлж байна. Ерөөсөө, бодлогыг улс төрийн өнцгөөр харж явуулаад байна. Бодлого бол өргөн хүрээг хамарсан, алсыг харсан зүйл байх ёстой. Тухайлбал, үндэсний аюулгүйн байдлын тухай бодлого гэж гарсан. Тэр бол ерөнхий зүйл. Дараа нь салбар салбараар нь гаргачихвал аль ч Засгийн газар, ямар ч улс төрийн хүчин Засгийн эрхэнд гарсан үүнийг баримталдаг байх учиртай. Үүний тод жишээ манай урд хөршид байна шүү дээ” гэв.

2.

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба “Засаг төр солигдох бүрт уул уурхайн ▶

салбарт хэрэгжиж буй хууль эрх зүйн баримт бичиг 180 градус эргэж болохгүй. “Урт нэртэй” хууль гар аргаар алт олборлогч нинжа нарт боломж олгохын зэрэгцээ байгаль орчинд маш том хор хохирол учруулах болсон. Тус хуулийн үр дүнд олон уурхайчин ажилгүй боллоо. Цаашид хууль тогтоомж боловсруулахдаа тодорхой тооцоо, судалгаанд үндэслэсэн байх ёстой. Өнгөрсөн цагаа харах бусирээдүйгээ харах ёстой. Уул уурхайгаас авч буй орлогоо зөв хуваарилах хэрэгтэй” хэмээн тайлбарласан юм. Манай улсын эдийн засгийн тулгуур, хөгжлийн тэргүүлэх “мотор” болсон салбар нь уул уурхай. Тиймээс төсөвт бүрдүүлж буй тус салбарын татварын орлого, хураамж, төлбөрөөр улс бараг л амьдарч, түүний хүчинд Монгол улс дангаар оршин тогтох эдийн засгийн дархан эрхтэй болоод буй. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах, олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна” гэж тэмдэглэсэн байдаг. Хэдий үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд уул уурхайн салбарын өгөөжийг тод томруун тусгасан ч эрх зүйн орчин нь тогтворгүй, улс төрийн нөлөөнд хэт автчих гээд цагийн бэрхийг туулж яваа гэж салбарынхан нь учирлах аж. »



Фотог Б.Бямба-ОЧИР

Уул уурхайн хуулиуд ба татвар, хураамж

Монгол улсын уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулах хуулиуд

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлохыг хориглох тухай хууль
- Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Ойн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Усны тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийн баримт бичгүүд гэх мэт.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь дараахь татвар, төлбөр, хураамжийг улсын болон орон нутгийн төсөвт оруулдаг байна.


1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
3. Авто тээврийн болон өөрөө явах хэрэгслийн албан татвар
4. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
5. Нэмэгдсэн өртгийн албан татвар
6. Импортын барааны гаалийн татвар
7. Онцгой албан татвар
8. Зарим бүтээгдэхүүний үнийн гэнэтийн өсөлтийн албан татвар
9. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
10. Газар ашигласны төлбөр
11. Ус ашигласны төлбөр
12. Зам ашигласны төлбөр
13. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр
14. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
15. Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр
16. Гаалийн үйлчилгээний хураамж
17. Орон нутгийн төсөвт төлсөн тэмдэгтийн хураамж
18. Төрийн захиргааны орон нутгийн байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс

Уул уурхайн салбарт хэрэгжиж буй татварын хувь хэмжээний өөрчлөлт нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл, мөн гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээнд шууд хамааралтай байдаг.



2012

Харилцаа тогтооё
Харилцан суралцъя
Хамтдаа хөгжье!



Үнэ төлбөргүй

Чуулга уулзалт, үзэсгэлэн

ГЕРМАН – МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ӨДРҮҮД

2012 оны 10 сарын 22-24
Blue Sky Зочид буудал
Улаанбаатар хот

22-ны өдөр: Технологийн шинэчлэл – Үйлдвэрлэлийг дэвшилтэт аргаар шинэчлэх нь

23-ны өдөр: Нийлүүлэлтийн сүлжээний менежмент – Өсөж буй зах зээлийн эрэлт хэрэгцээг оновчтой хангах нь

24-ний өдөр: Бизнесийн менежмент 2.0 – Өөрчлөгдөн хөгжиж буй Монгол улсын хөрсөн дээр буулгасан менежмент

Таны давуу талууд:

Герман-Монголын бизнесийн өдрүүд 2012 арга хэмжээнд оролцсоноор Та ирээдүйн бизнесийн түншүүдтэйгээ мэргэжлийн хүрээнд мэдлэг туршлагаа харилцан солилцох боломжтой. Та чуулга уулзалтын үеэр бидний зохион байгуулж буй Үзэсгэлэнд зочилно уу.

Зохион байгуулагч:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага” хөтөлбөр

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Хамтран зохион байгуулагч:



Deutsch-Mongolischer
Unternehmerverband

Холбоо барих:

7011 7704
imri@giz.de
www.giz.de
www.imri-mn.com



Санхүүгийн зах зээлийн холбоо

Энэ оны нэрлэсэн үнээр ДНБ өмнөх оны мөн үеэс эхний хагас жилд 25.2 хувиар өсч, 6185.7 тэрбум төгрөгт хүрлээ. Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) өнгөрсөн наймдугаар сард түрүү сараас 0.7 хувь, оны эхнээс 11.1

хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.9 хувиар дээшилжээ. Түүнчлэн ерөнхий индекс өнгөрсөн сартай харьцуулахад өссөн байгаа нь боловсролын үйлчилгээний үнэ 15.2 хувиар өссөнтэй шууд холбоотой аж.


Монголын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд. Өмнөх оны мөн үетэй харьцуулсанаар /хувиар/

ДНБ		Үйлдвэрлэл	Хэрэглэгчийн индекс		Ажилгүйдлийн үзүүлэлт, %	Төлбөрийн тэнцэл		Төсвийн тэнцэл	Зээлийн хүү	Валютын ханш	
Хамгийн сүүлд	2012	Хамгийн сүүлд	Хамгийн сүүлд	Хамгийн сүүлд		Хамгийн сүүлд	ДНБ-д эзлэх хувиар	ДНБ-т эзлэх хувиар 2012		12.10.05	Жилийн өмнө
16,90%	15,01%	7,80%		11,10%	3,60%	(-1430) сая \$	24,12%	2,40%	13,25	1382,65	1291,71

Таваарын үнэ ханш

Таваар	Хэмжүүр	Төгрөг	ам.доллар		Өөрчлөлт хувиар
			12.09.21	12.10.05	
Алт	Трой Унци	2 469 067,24	1 668,00	1 785,75	7,06
Мөнгө	Трой Унци	48 143,87	34,60	34,82	0,64
Зэс	Паунд	5 226,42	3,76	3,78	0,53
Уран	Паунд	63 256,24	46,80	45,75	-2,24
Төмрийн хүдэр	Метр тонн	157 483,84	113,90	113,90	0,00
Молибдениум	Паунд	14 739,05	10,89	10,66	-2,11

UBIBOR




Мөнгөний зах зээл /хувиар/

LIBOR	Энэ долоо хоног	Сарын өмнөх	Жилийн өмнөх
Нэг сарын үзүүлэлт	0,22	0,23	0,24
Гурван сарын үзүүлэлт	0,35	0,41	0,38
Зургаан сарын үзүүлэлт	0,63	0,7	0,57
Нэг жилийн үзүүлэлт	0,97	1,03	0,86

Мөнгөний зах зээл /хувиар/

UBIBOR	12.09.21	12.10.06
Нэг өдрийн	13,2500	13,2429
Нэг долоо хоногийн үзүүлэлт	13,5357	13,5929
Нэг сарын үзүүлэлт	14,5143	14,6286
Гурван сарын үзүүлэлт	15,3286	15,5286
Зургаан сарын үзүүлэлт	16,0143	16,1500
Нэг жилийн үзүүлэлт	17,1214	17,2214

Хөрөнгийн зах зээл



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, Төрийн өмчийн хороо болон Лондоны хөрөнгийн биржийн хооронд байгуулсан стратегийн хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ”-ний хүрээнд хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлуудыг тодорхой үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж байна.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК энэ оны долдугаар сарын 2-нд арилжаа, төлбөр тооцоо, хянатын цогц шийдэл бүхий “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлсэн билээ. Шинэ систем болон хууль, эрх зүйн актаар тавигдаж буй шаардлагуудыг бүрэн хангасан 44 брокер, диллерийн компани өнөөдөр хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцож байгаа бөгөөд олон жилийн дунджаас харахад эдгээр брокер, диллерийн компани зах зээлийн нийт арилжааны 95 хувийг бүрдүүлж байна.

Энэ оны эхний есөн сарын байдлаар нийт 142.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 81.3 тэрбум төгрөгөөр буюу 2.3 дахин их, харин өнгөрсөн оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 33.4 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн байна.

2012 оны эхний хагас жилийн байдлаар нийт 61 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийж, өдрийн дундаж арилцааны хэмжээ 463 сая төгрөг байсан бол өнгөрсөн долдугаар сарын 2-ноос буюу шинэ системийг ашиглалтад оруулсан өдрөөс өнөөдрийг хүртэл 81.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааны арилжаа хийгдэж, өдрийн дундаж арилжааны хэмжээ 1.4 тэрбум төгрөгт хүртлээ өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Эх сурвалж: www.mse.mn

ТОП 20-ийн хувьцаа

№	МХБ TOP 20	Төрөг		Өөрчлөлт	ам.доллар	Зах зээлийн үнэлгээ /ам.доллар/
		21.IX	05.X			
1	АПУ	3885	3400	-12,48%	2,496	252 578 180 000
2	Багануур	5490	6000	9,29%	4,404	125 846 160 000
3	Баянгол зочид буудал	39000	38360	-1,64%	28,155	16 228 773 400
4	BDSec	3470	3450	-0,58%	2,532	37 950 000 000
5	Говь	3837	3850	0,34%	2,826	30 034 331 250
6	Женко тур	92	20	-78,26%	0,015	2 000 000 000
7	Могойн гол	15000	15000	0,00%	11,010	12 444 330 000
8	Монгол шилтгээн	1000	1000	0,00%	0,734	10 000 000 000
9	Монголиа девелопмент ресорсес	900	900	0,00%	0,661	12 375 000 000
10	Монголын цахилгаан холбоо	2000	2000	0,00%	1,468	51 740 552 000
11	Ремикон	192	188	-2,08%	0,138	14 791 739 232
12	Силикат	180	189	5,00%	0,139	8 757 239 778
13	Сүү	80000	80000	0,00%	58,718	27 520 000 000
14	Тавантолгой	9300	9000	-3,23%	6,606	241 733 700 000
15	Талх чихэр	12000	12500	4,17%	9,175	12 796 287 500
16	Улаанбаатар зочид буудал	70000	72500	3,57%	53,213	24 309 032 500
17	Улсын их дэлгүүр	401	400	-0,25%	0,294	14 723 140 000
18	Хөх ган	185	185	0,00%	0,136	3 700 000 000
19	Шарын гол	9150	9000	-1,64%	6,606	92 082 501 000
20	Шивээ-Овоо	10400	10000	-3,85%	7,340	134 191 010 000

ТОП 20 индекс

12.01.01	12.09.30	өөрчлөлт
20869,4	17095,39	-18,08%

Гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын уул уурхайн компаниудын хувьцаа

	Бирж	Валют	12.10.05
Оюу толгой ресурс	Торонто	CAD	8,41
Сауд гоби ресурс	Торонто	CAD	2,02
Сентерра гоулд	Торонто	CAD	12,74
Энтрий гоулд	Торонто	CAD	0,57
Петро матад	Лондон	GBP	7,84
Монголиан энержи корп	Хонконг	HKD	0,34
Монголын уул уурхайн корп	Хонконг	HKD	3,54

Өнгөрсөн оны оны наймдугаар сараас эхлэн уналттай явж ирсэн алтны үнэ энэ оны дундаас өсөх хандлагатай болсон билээ. Эдийн засаг санхүүгийн хямрал болох үеэр үнэт цааснуудын үнэ буурдаг бол алт эсрэгээрээ өсөх хандлагатай байдаг. Сүүлийн үед дэлхийн эдийн засгийн байдал тогтворгүй байгаагаас үүдэн хүмүүсийн хүлээлт сөрөг тийшээ чиглэж, алтны эрэлт ихсэж үнэ өссөн байж болох. ■

Алтны үнэ 1,770.88 ам.доллар /2012.10.8/



“Форд мотор” компани “Хүрээлэн буй орчин болон байгаль хамгааллын тэтгэлэгт хөтөлбөр” зарлаж, шалгарсан төслүүдэд санхүүжилт олголоо

“Вагнер Ази Автомотив Форд”-ын “Хүрээлэн буй орчин болон байгаль хамгааллын чиглэлийн төслүүдийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр”-ийн дүнгээ гаргаж, тэтгэлэгийн эздийг олон нийтэд зарлалаа. 2012 оны есдүгээр сарын 25-нд хэвлэлийн хурал хийж тэтгэлгийг олголоо.



100 гаруй жилийн түүхт “Форд” автомашиныг үйлдвэрлэгч “Форд мотор” компани нийгмийн хариуцлагын хүрээнд байгальд ээлтэй технологийн шийдэл бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг бизнесийнхээ нэг зорилго болгож энэ чиглэлийн олон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, санхүүжүүлэх үйл ажиллагааг дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаагаа явуулж байгаа дилерүүдээрээ

дамжуулан явуулдаг билээ. Үүний нэг нь Ази Номхон далайн бүсийн орнуудын дилерийн дунд 30-аад жилийн турш зохион байгуулж байгаа “Хүрээлэн буй орчин болон байгаль хамгааллын чиглэлийн төслүүдийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр” юм. Энэ жил анх удаагаа “Вагнер Ази Автомотив” компани Монгол дахь “Форд”-ын албан ёсны дилерийн хувьд Монгол улсад зохион байгууллаа.



Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан төслүүдийг шинэ технологийн санал санаачилгыг дэмжих, байгаль хамгааллын боловсрол олгох, нийгэм орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн үндэслэлүүдийг баримталж Байгаль орчины яамнаас томилогдсон мэргэжлийн болон салбарын мэргэшсэн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй шүүх багаар хэлэлцэн хоёр шаттайгаар шалгарууллаа. Тэтгэлэгт хөтөлбөрийг өнгөрсөн наймдугаар сарын 1-нээс эхлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан бөгөөд хөтөлбөрт хот хөдөө орон нутгийн олон нийтийн байгууллагууд Байгаль хамгаалал нутгийн хөгжлийн төрийн бус байгууллагууд,

эрдэмтэн доктор судлаачдын баг, оюутан залуучуудын хамтарсан сайн дурын төслийн багуудын ирүүлсэн төслүүд хамрагдлаа. “Вагнер Ази Автомотив” болон төслүүдийг шүүх багийн бүрэлдэхүүн харилцан санал солилцож шүүх явцдаа төслүүдэд тавигдсан үндсэн шалгууруудыг харгалзаж үзэхийндээр тэтгэлэгт аль болох олон төслүүдийг хамруулах, нийгэм орон нутгийн хөгжилд тухайн орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, техник технологийн шинэ ололт санаачлагуудыг дэмжих, байгаль хамгааллын боловсролыг олгох гэсэн үндэслэлүүдийг харгалзан дөрвөн төслийг шалгаруулж нийт 15000 ам.долларын тэтгэлэгийг тодорхой хувиар хуваарилан олголоо.



Тэтгэлэгт хөтөлбөрт амжилттай оролцон зуун хувийн санхүүжилт авсан Толгойтын нутгийн хөгжлийн төв ТББ-аас ирүүлсэн “Толгойт хороололд цэцэрлэгт хүрээлэн байгуулах” төслийн нийгмийн хөгжилд иргэдийн оролцоо оролцоог нэмэгдүүлэх гол зорилгод ач холбогдол өгч зуун хувь санхүүжүүлэхээр шийдвэрлэлээ.



Шинэ техник технологи нэвтрүүлэх нь аливаа нэг хөгжлийн бас нэг чухал үндэс болдог гэсэн үндэслэлээр технологийн чиглэлээр ирүүлсэн хоёр төсөлд ижил хэмжээний санхүүжилтийг олгохоор шийдвэрлэлээ. Үүнд: Шинжлэх ухааны академийн дэргэдэх Биологийн хүрээлэнгийн эрдэмтэн багш судлаачдаас бүрдсэн төслийн багийн ирүүлсэн “Харгиа цэвэрлэх байгууламжийн лаг бохирдлыг Монголд тарьж ургуулсан омгийн бичил биетнийг ашиглаж бууруулах” гэсэн төслийг дэмжлээ.



Шинжлэх ухаан үйлдвэрлэлийн БИОС нийгэмлэгээс ирүүлсэн “Хаягдал Модыг ашиглан Пиролизын аргаар жижиг оврын цахилгаан үүсгүүр гарган авах” гэсэн төслийг дэмжлээ.



Залуу боловсон хүчнийг дэмжих урамшуулах зорилгоор “Эко тэнцвэр” оюутан судлаачдын сайн дурын төслийн багийг дэмжиж тэдний ирүүлсэн “Ногоон бордоо-хөрс хамгаалах” гэсэн төслийг 2000 ам.доллараар санхүүжүүлж урамшуулахаар боллоо.

